# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

# КОМПАНИЙН ТУХАЙ

1999 оны 7 дугаар сарын 2-ны өдөр
Улаанбаатар хот

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### Нийтлэг үндэслэл

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь компани үүсгэн байгуулах, бүртгэх, өөрчлөн байгуулах, компанийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувь нийлүүлэгчдийн эрх, үүргийг тогтоох болон компани татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**

2.1. Энэ хууль болон Монгол Улсын бусад хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа бүх компани өмчийн хэлбэр, эд хөрөнгийн болон үйлдвэрлэлийн хэмжээ, дотоод зохион байгуулалтаас үл хамааран энэ хуулийг дагаж мөрдөнө.

2.2. Банк, санхүү, даатгал, үнэт цаасны салбарт компани үүсгэн байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааны онцлогтой холбогдсон асуудлыг бусад хуулиар, нийтлэг асуудлыг энэ хуулиар тус тус зохицуулна.[1]

2.3. Төрийн өмчит үйлдвэрийн газрыг хувьчлах замаар байгуулагдсан компанийн үйл ажиллагааг энэ хуулиар, тэдгээрийг үүсгэн байгуулахтай холбогдсон харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар1 зохицуулна.

2.4. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанид төрийн ба орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулна.

2.5. Төрийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан өөрчлөн зохион байгуулах замаар үүссэн төрийн өмчит компанийн үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулна. Энэ тохиолдолд өмчлөгч нь төр байх бөгөөд хувь нийлүүлэгчид нь Засгийн газраас эрх олгосон төрийн захиргааны байгууллага байна.

2.6. Компаниас өөр хэлбэрийн ашгийн төлөө үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг байгуулахтай холбогдсон харилцаа, тэдгээрийн үйл ажиллагааг бусад хуулиар зохицуулна.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

***Компани, түүний эрх зүйн байдал***

**3 дугаар зүйл. Компани, түүний хэлбэр**

3.1. Хувь нийлүүлэгчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгаарласан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ.

3.2. Хувьцаа нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд компанийн аливаа нэг эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.

**3.3. Хувьцаа эзэмшигчийн эрхийг энэ хууль болон компанийн дүрмээр тогтооно. Хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах, хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож хэлэлцэж байгаа бүх асуудлаар болон зарим асуудлаар санал өгөх, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг үндсэн эрх эдэлнэ.**

3.4. Компани нь дараахь хэлбэртэй байна:

3.4.1. хувь нийлүүлэгчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь нийтэд чөлөөтэй арилжаалагддаг нээлттэй буюу хувьцаат компани;

Нийтлэгдсэн:"Төрийн мэдээлэл", 19… он, Дугаар …, Хуудас … дугаар тал

3.4.2. хувь нийлүүлэгчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь компанийн дүрмээр хязгаарлагддаг хаалттай буюу хязгаарлагдмал хариуцлагатай компани .

**4 дүгээр зүйл. Нээлттэй буюу хувьцаат компани**

***4.1. Нээлттэй буюу хувьцаат компанийн /цаашид энэ хуульд "хувьцаат компани" гэх/ хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшиж байгаа хувьцааг чөлөөтэй захиран зарцуулах эрх эдэлнэ.***

***4.2. Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн тоог компанийн дүрмээр хязгаарлахгүй.***

4.3. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хувьцаат компани нь нээлттэй буюу хаалттай захиалгын үндсэн дээр хувьцаа болон бусад үнэт цаас гаргаж болно. Хаалттай захиалгын үндсэн дээр нэмж гаргасан хувьцааг худалдан авагч нь цаашид түүнийг чөлөөтэй захиран зарцуулах эрх эдэлнэ.

***4.4. Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчид өөр хоорондоо тохиролцсоны үндсэн дээр хувьцаагаа захиран зарцуулах эрхээ харилцан хязгаарласан гэрээ байгуулж болно. Энэ гэрээний үйлчлэх хугацаа нь 10 жилээс дээшгүй байх бөгөөд гэрээг хэдэн ч удаа сунгаж болно.***

**5 дугаар зүйл. Хаалттай буюу хязгаарлагдмал хариуцлагатай компани**

5.1. Хаалттай буюу хязгаарлагдмал хариуцлагатай компанийн /цаашид энэ хуульд "хязгаарлагдмал хариуцлагатай компани " гэх / үүсгэн байгуулагчдын тоо 50-иас дээшгүй байна. Хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулагдсаны дараа хувьцаа эзэмшигчдийн тоог хязгаарлахгүй.

5.2. Хязгаарлагдмал хариуцлагатай компани нь хувьцаа, тэдгээрийг худалдан авах эрхийн бичиг болон тэдгээрт хөрвөх үнэт цаасыг зөвхөн хаалттай захиалгын үндсэн дээр гаргана. Тэдгээрээс бусад үнэт цаасыг компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хувьцаат ба хаалттай захиалгын үндсэн дээр гаргаж болно.

5.3. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид нь компанийн бусад хувьцаа эзэмшигчийн худалдах хувьцаа, тэдгээрийг худалдан авах эрхийн бичиг болон тэдгээрт хөрвөх үнэт цаасыг гурав дахь этгээдэд санал болгох үнээр эзэмшиж байгаа хувьцааныхаа тоонд хувь тэнцүүлэн энэ зүйл болон компанийн дүрэмд заасан журмын дагуу тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.

5.4. Хувьцаагаа худалдахаар санал тавьж байгаа хувьцаа эзэмшигч нь саналаа бусад хувьцаа эзэмшигчдэд бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд худалдах гэж байгаа хувьцааны төрөл, тоо, худалдах үнэ, тэргүүн ээлжинд худалдан авч болох хувьцааны тоо, худалдан авах хугацаа, журмыг тодорхойлсон байна.

Хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах хувьцаа эзэмшигч нь энэ шийдвэрээ тогтоосон хугацааны дотор бичгээр компанид мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд худалдан авч байгаа хувьцаа эзэмшигчийн овог, нэр, хаяг, худалдан авах хувьцааны тоо, төлбөр хийсэн баримт зэргийг тусгасан байна. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг тэргүүн ээлжинд авах эрхээ бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хэрэгжүүлэх, эсхүл энэ эрхээ бүхэлд нь буюу зарим хэсгийг нь бусад хувь нийлүүлэгчдэд шилжүүлэх эрхтэй.

5.5. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 5.3-т заасан эрхийг хувьцаа эзэмшигч тогтоосон хугацаанд бүрэн эдлээгүй тохиолдолд тэдгээрийг худалдан авах эрх компанид шилжих бөгөөд компани нь энэ эрхийг мэдэгдэлд заасан хугацаа дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор хэрэгжүүлнэ.

5.6. Энэ хуулийн 5.3, 5.5-д заасан этгээдүүд тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлээгүй тохиолдолд хувьцаагаа худалдахаар санал тавьж байгаа хувьцаа эзэмшигч нь мэдэгдэлд заасан үнээс багагүй үнээр гуравдагч этгээдэд худалдах эрхтэй.

**6 дугаар зүйл. Хараат болон охин компани**

6.1. Компанийн нийт энгийн хувьцааны 20-51 хүртэл хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа тохиолдолд уг компанийг хараат компани гэнэ. Хараат компани нь бие даасан тайлан баланс гаргадаг хуулийн этгээд байна.

6.2. Компанийн нийт энгийн хувьцааны 51-ээс 100 хүртэл хувийг өөр /толгой/ компани дангаараа эзэмшдэг бие даасан хуулийн этгээдийг охин компани гэнэ. Охин компани нь тусдаа санхүүгийн тайлан гаргахын зэрэгцээ толгой компанитайгаа нэгдсэн тайлан гаргана.

6.3. Хараат болон охин компани нь толгой компанийн өрийг хариуцахгүй бөгөөд тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол толгой компани нь хараат болон охин компанийн өрийг хариуцахгүй.

6.4. Толгой компани нь гуравдагч компанийн хараат болон охин компани байвал түүний охин компани нь гуравдагч компанийн хувьд мөн хараат болон охин компани болох бөгөөд энэ зарчмыг үүнээс ч илүү үргэлжилсэн хэлхээ холбоонд ашиглан хамаарлыг тогтооно.

6.5. Хараат болон охин компани нь толгой компанийн хувьцааг эзэмшиж болно. Охин компанийн эзэмшиж байгаа хувьцаа нь саналын эрхгүй бөгөөд хувь нийлүүлэгчдийн хурлын ирцийг тооцохдоо тэдний эзэмшиж байгаа хувьцааг хасч тооцно. Эдгээр хувьцааг гуравдагч этгээдэд шилжүүлэхэд уг этгээдэд хувьцааны бүх эрх шилжинэ.

6.6. Компани өөрийн хараат болон охин компани, тэдгээрийн хараат, охин компаниуд болон бусад компанитай үйл ажиллагаагаа уялдуулах зорилгоор нэгдэж болно.

6.7. Нэгдлийн оролцогчид нь бие даасан хуулийн этгээд хэвээр байх бөгөөд оролцогчдын үйл ажиллагааг уялдуулахад чиглэсэн харилцааг Иргэний хуульд1 заасан журмын дагуу байгуулсан гэрээгээр зохицуулна.

6.8. Энэ хуулийн 6.7.-д заасан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээс бусад тохиолдолд толгой компани нь хараат болон охин компанийн үйл ажилагаанд зөвхөн эзэмшиж байгаа хувьцааны эрхээр оролцоно

**7 дугаар зүйл. Компанийн салбар, төлөөлөгчийн газар**

7.1. Компанийн салбар нь компанийн оршин байгаа газраас өөр газар байрладаг тусгай нэгж бөгөөд компанийн үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь, түүнчлэн төлөөлөгчийн газрын үүргийг гүйцэтгэж болно.

7.2. Компанийн төлөөлөгчийн газар нь компанийн оршин байгаа газраас өөр газар байрладаг нэгж бөгөөд компанийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх зэрэг эрх зүйн төлөөллийн үйл ажиллагаа явуулна.

7.3. Компани нь Монгол Улсад болон гадаадад өөрийн салбар, төлөөлөгчийн газартай байж болно. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол салбар, төлөөлөгчийн газар байгуулах тухай шийдвэрийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/гаргана.

7.4. Гадаадын хуулийн этгээдийн Монгол Улсад оршин байгаа салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэх байгууллагад бүртгүүлнэ. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаадад салбар, төлөөлөгчийн газар байгуулах асуудлыг тухайн улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

7.5. Компанийн салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрхийг эдлэхгүй бөгөөд түүнийг байгуулсан компаниас баталсан журмын дагуу үйл ажиллагаа эрхлэн явуулна. Салбар, төлөөлөгчийн газрын эд хөрөнгийг түүнийг байгуулсан компанийн балансt тусгана.

7.6. Компанийн салбар, төлөөлөгчийн газар нь үйл ажиллагаагаа түүнийг байгуулсан компанийн нэрийн өмнөөс явуулна. Компани нь өөрийн салбар, төлөөлөгчийн газрын хүлээх үүргийг хариуцна.

7.7. Компани нь өөрийн салбар, төлөөлөгчийн газрын эрх баригчийг томилох бөгөөд тэдгээр нь компаниас олгосон итгэмжлэлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулна.

**8 дугаар зүйл. Компанийн үйл ажиллагааны чиглэл, байгуулах хугацаа**

8.1. Компани нь хуулиар хориглоогүй бүх төрлийн үйл ажиллагаа эрхэлж болох бөгөөд компани эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах эрх, үүргийг хүлээнэ.

8.2. Компанийн эрхлэх үйл ажиллагааны хүрээг дүрмээр хязгаарлаж болно. Ингэж хязгаарласан нь энэ хязгаарлалтыг мэдэхгүйгээр хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа гуравдагч этгээдийн өмнө уг компанийн хүлээсэн үүргээ биелүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

8.3. Хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа эрхлэх компани нь холбогдох эрх бүхий байгууллагаас бичгээр олгосон зөвшөөрлийн үндсэн дээр энэ үйл ажиллагааг эрхлэн явуулна.

8.4. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компанийг тодорхой бус хугацаагаар үүсгэн байгуулна.

**9 дүгээр зүйл. Компанийн болон хувь нийлүүлэгчдийн хариуцлага**

9.1. Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.

9.2. Компани нь хувьцаа эзэмшигчдийн хүлээх үүргийг хариуцахгүй.

9.3. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

9.4. Дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч болон бусад хэлбэрээр компанийн үйл ажиллагааг тодорхойлох эрх бүхий этгээдийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан эд хөрөнгийн хохирлыг уг этгээд өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцна.

9.5. Хувь нийлүүлэгчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувь нийлүүлэгч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна.

**10 дугаар зүйл. Компанийн оноосон нэр, оршин байгаа газар**

10.1. Компани оноосон нэртэй байх бөгөөд түүнийг хэрэглэх тохиолдол бүрд уг нэрийн ард компанийн хэлбэрийг тодорхойлсон хувьцаат компани буюу "ХК", хязгаарлагдмал хариуцлагатай компани буюу "ХХК" гэсэн ялгах тэмдэглэл заавал заасан байна.

10.2. Компанийн оноосон нэр нь бусад компани, аж ахуйн нэгжийн оноосон нэртэй давхардаагүй байх бөгөөд компани оноосон нэрээ бүртгэх байгууллагад бүртгүүлснээр уг оноосон нэрийг хэрэглэх онцгой эрх авна.

10.3. Компани нь бүртгэх байгууллагад бүртгэгдсэн өөрийн бэлгэдэл болон барааны тэмдэгтэй байж болно.

10.4. Компанийн оршин байгаа газар, шуудангийн хаягийг түүний ерөнхий захиргаа байршин байгаа газраар тодорхойлно. Тэдгээрийн өөрчлөлтийг тухай бүр бүртгэх байгууллагад мэдэгдэнэ.
*/Энэ хэсэгт 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Компани байгуулах

**11 дүгээр зүйл. Компани байгуулах**

11.1. Компанийг шинээр буюу хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах /нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх/ замаар байгуулж болно.

11.2. Компанийг хувьчлах замаар үүсгэн байгуулах тохиолдолд үүсгэн байгуулагчийн үүргийг төр хүлээх бөгөөд хувьцааны захиалга авах, худалдах, шилжүүлэх ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ.

**12 дугаар зүйл. Компанийн үүсгэн байгуулагч**

12.1. Компанийн үүсгэн байгуулагч нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, түүнчлэн хуульд заасан бол гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн байж болно.

12.2. Компаниас гаргасан хувьцааг иргэн, хуулийн этгээд, гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн эзэмшиж болно.

12.3. Компани нэг үүсгэн байгуулагчтай байж болно.

12.4. Компанийн үүсгэн байгуулагч нь тухайн компанийн хувьцааг эзэмшихгүй байж болно.

12.5. Төр, түүний байгууллага нь дараахь тохиолдолд компанийн үүсгэн байгуулагч болон түүний хувь нийлүүлэгч байж болно:

12.5.1. төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг хувьчилснаар шинээр бий болсон компанийн;

12.5.2. төрийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан өөрчлөн байгуулах замаар үүссэн төрийн өмчит компанийн;

12.5.3. хууль тогтоомжид заасан журмын дагуу дампуурч байгаа компанийн төрд төлөх өрийг хувьцаагаар нь сольж авсан компанийн. Энэ тохиолдолд төр эдгээр хувьцааг 3 жилийн дотор бусад этгээдэд худалдах үүрэгтэй;

12.5.4. гадаадын хуулийн этгээдтэй хамтран байгуулсан компанийн;

12.5.5. хуульд заасан бусад.

12.6. Компанийг үүсгэн байгуулах, улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбогдсон зардлыг компанийн үүсгэн байгуулагчид хамтран хариуцна. Үүсгэн байгуулах хурлын буюу төлөөлөн удирдах зөвлөл / хэрэв нэг үүсгэн байгуулагчтай бол үүсгэн байгуулагч/-ийн шийдвэрээр энэ зардлыг компани хариуцаж болно.

12.7.Компанийг үүсгэн байгуулахтай холбогдсон зардлыг төлсөн этгээд нь бусад үүсгэн байгуулагчдаас эзэмшиж байгаа болон эзэмшихээр захиалсан хувьцааны тоотой нь хувь тэнцүүлэн энэ зардлыг нэхэмжлэн авах, эсхүл гаргасан зардлынхаа хэмжээнд хувьцаа эзэмших эрхтэй.

12.8. Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь бусад компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч байж болно.

**13 дугаар зүйл. Шинээр компани үүсгэн байгуулах**

13.1. Энэ хуулийн 13.2.-т заасны дагуу боловсруулсан төслийг нийтэд /хувьцаат/ санал болгож хувьцааны захиалга авах, эсхүл цөөн тооны этгээдээс /хаалттай/ захиалга авах аргаар шинээр компани үүсгэн байгуулж болно.

13.2. Хувьцааны захиалга авах аргаар шинээр компани үүсгэн байгуулах төсөлд дор дурдсан зүйлийг тусгана:

13.2.1. эрхлэх үйл ажиллагааны чиглэл;
13.2.2. хувь нийлүүлсэн хөрөнгийн төлөвлөсөн хэмжээ;
13.2.3. зарлах хувьцааны тоо, нэрлэсэн үнэ;
13.2.4. шаардлагатай гэж үзвэл үйл ажиллагаа явуулах хугацаа;
13.2.5. төлөвлөсөн ашгийн хэмжээ;
13.2.6. захиалга эхлэх, дуусах хугацаа.

13.3. Нийтэд санал болгосон хувьцааны захиалга авахтай холбогдсон харилцааг Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан журмын дагуу зохицуулна.

*/Энэ хэсэгт 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

13.4. Хувьцааны захиалгыг захиалгын хуудсаар авах бөгөөд түүнд захиалагчийн овог, нэр, захиалсан хувьцааны төрөл , ангилал, тоо, үнийн дүн, захиалсан огноо зэрэг зүйлийг тусгах бөгөөд захиалагч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурсанаар захиалга хийгдсэнд тооцно.

13.5. Захиалсан нийт хувьцааны 30 хувьтай тэнцэх төлбөрийг захиалгын хугацаа дууссанаас хойш ажлын 30 хоногийн дотор хийнэ.

13.6. Төлбөр хийгдсэн хувьцааны үнийн дүн нь хуулиар тогтоосон өөрийн хөрөнгийн доод хэмжээнд хүрсэн бол компани байгуулах нөхцөл бүрдсэн гэж үзнэ.

13.7. Компани үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэрээр компанийг үүсгэн байгуулна. Компанийг нэг этгээд байгуулж байгаа тохиолдолд тухайн этгээд нь үүсгэн байгуулах шийдвэр гаргана.

13.8. Компанийг нэгээс илүү үүсгэн байгуулагч байгуулах нөхцөлд үүсгэн байгуулагчид нь компанийг үүсгэн байгуулах талаар хамтран ажиллах гэрээ байгуулж болох бөгөөд энэ гэрээнд үүсгэн байгуулагчдын хамтран ажиллах журам, үүсгэн байгуулагч тус бүрийн хүлээх үүрэг, тэдгээрийн худалдан авах хувьцаа болон бусад үнэт цаасны ангилал, төрөл тус бүрийн тоо, үнэ, худалдан авах хугацаа зэрэг шаардлагатай гэж үзсэн бусад асуудлыг тусгана. Энэ гэрээ нь компанийг үүсгэн байгуулах баримт бичигт хамаарахгүй.

13.9. Хувьцаагаа нийтэд санал болгон худалдахаар шийдвэрлэсэн компани бүртгэх байгууллагад бүртгүүлснээс хойш ажлын 10 хоногийн дотор нийтэд санал болгож байгаа хувьцаагаа Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлнэ.
*/Энэ хэсэгт 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

**14 дүгээр зүйл. Компани үүсгэн байгуулах хурал**

14.1. Компани үүсгэн байгуулах хурлыг үүсгэн байгуулагчид зарлан хуралдуулна.

14.2. Үүсгэн байгуулагчид санал нэгтэйгээр өөрөөр шийдвэрлээгүй бол үүсгэн байгуулагч бүр үүсгэн байгуулах хуралд саналын тэнцүү эрхтэй оролцоно.

14.3. Үүсгэн байгуулах хурлаар дараахь асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

14.3.1.компани байгуулах тухай шийдвэр;
14.3.2. компанийн дүрэм;

14.3.3. зарласан болон гаргах хувьцаа, тэдгээрээс үүсгэн байгуулагчдын худалдан авах үнэ;

14.3.4. төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол түүний гишүүдийг сонгох, тэдгээрийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

14.3.5. хянан шалгах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол түүний гишүүдийг сонгох, тэдгээрийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

14.3.6. компани үүсгэн байгуулахад гаргасан зардлыг нөхөн олгох журам;

14.3.7.захиалсан хувьцааны төлбөрийн үлдэгдлийг төлж дуусгах хугацаа.

14.4. Үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх үүсгэн байгуулагчид оролцсоноор хурал хүчин төгөлдөр болох бөгөөд шийдвэрийг хуралд оролцогчдын дийлэнх олонхийн саналаар гаргана.

14.5. Хурал даргалагчийг үүсгэн байгуулагчдаас сонгоно.

14.6. Үүсгэн байгуулагчид мөнгөн бус хэлбэрээр төлбөр хийх тохиолдолд санал болгож байгаа эд хөрөнгийнхээ үнийн талаар шаардлагатай гэж үзвэл үнэлгээний байгууллага болон

холбогдох мэргэжлийн шинжээчдийн дүгнэлт гаргуулан санал боловсруулж үүсгэн байгуулах хуралд оруулна.

14.7. Мөнгөн бус хэлбэрээр хийгдэж байгаа эд хөрөнгийн үнийг үүсгэн байгуулах хуралд оролцогчид санал нэгтэй шийдвэрлэнэ.

14.8. Хэрэв ямар нэгэн шалтгаанаар компани байгуулагдаагүй бол захиалагчийн урьдчилан хийсэн төлбөрийг үүсгэн байгуулах хурал товолсон өдрөөс хойш ажлын 14 хоногийн дотор нөхөн олгох үүргийг үүсгэн байгуулагчид хүлээнэ.

**15 дугаар зүйл. Компанийг улсын бүртгэлд бүртгүүлэх**

15.1. Компани байгуулах тухай шийдвэр гарсанаас хойш ажлын 10 хоногийн дотор компанийг улсын бүртгэлд бүртгүүлэхээр холбогдох баримт бичгийг бүртгэх байгууллагад өгнө.

15.2. Компанийг бүртгүүлэхэд дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

15.2.1. компанийн оноосон нэр, оршин байх газар зэргийг заасан эрх бүхий этгээдийн гарын үсэг бүхий бүртгүүлэх тухай өргөдөл, уг өргөдөлд тухайн компанитай харилцах шуудангийн хаягийг заавал заасан байна;

15.2.2. компани байгуулах тухай үүсгэн байгуулах хурлын шийдвэр;
15.2.3. компанийн дүрэм;
15.2.4. бүртгэлийн хураамж төлсөн баримт ;
15.2.5. бүртгүүлэх өдөр байх ёстой өөрийн хөрөнгийн доод хэмжээг харуулсан эхлэлтийн баланс.

15.3. Компанийг бүртгэхэд бүртгэх байгууллага нь энэ зүйлд зааснаас бусад баримт бичиг шаардах буюу баримт бичгийн агуулгад шаардлага тавьж үл болно.

15.4. Бүртгэх байгууллага өргөдлийг хүлээн аваад дараахь зүйлийг хянан үзнэ:

15.4.1. энэ хуулийн 15.2-т заасан баримт бичиг бүрэн бүрдсэн эсэх;
15.4.2. компанийн дүрэмд энэ хуулийн 16.2.-т заасан зүйлийг тусгасан эсэх;
15.4.3. компанийн оноосон нэр нь бусад компани, нөхөрлөлийн оноосон нэртэй давхардсан эсэх;

15.4.4. эхлэлтийн балансанд тусгагдсан компанийн өөрийн хөрөнгө нь энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан доод хэмжээнд хүрсэн эсэх.

15.5. Бүртгэх байгууллага энэ хуулийн 15.2.-т заасан баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор компанийг улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгох, эсхүл компанийг бүртгэхээс татгалзсан үндэслэл бүхий шийдвэр гаргана.

15.6. Компанийг улсын бүртгэлд бүртгэх тухай энэ хуулийн 15.4.-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд компанийг бүртгэхээс татгалзана.

15.7. Бүртгэх байгууллага компанийг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан тухай шийдвэр гарсанаас хойш ажлын 3 хоногийн дотор татгалзах үндэслэлийг тусгасан мэдэгдлийг өргөдөлд заасан шуудангийн хаягаар өргөдөл гаргасан этгээдэд хүргүүлнэ. Бүртгэх байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрвөл үүсгэн байгуулагчид шүүхэд гомдол гаргаж болно.

15.8. Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах замаар байгуулагдсан компанийг энэ зүйлд заасан журмын дагуу дараахь баримт бичгийг үндэслэн улсын бүртгэлд бүртгэнэ:

15.8.1 .өөрчлөн байгуулагдсан компани /компаниуд/-ын эрх бүхий төлөөлөгчийн гарын үсэг бүхий бүртгүүлэх тухай өргөдөл;

15.8.2. хуулийн этгээд /хуулийн этгээдүүд/-ийг өөрчлөн байгуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр;

15.8.3. шинээр байгуулсан компанийн дүрэм;

15.8.4. хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани болгон өөрчлөн байгуулсан тохиолдолд нийтэд санал болгосон хувьцаагаа Үнэт цаасны тухай хуульд заасан журмын дагуу бүртгүүлэх зөвшөөрөл авсан тухай Үнэт цаасны хорооны шийдвэр;

15.8.5. өөрчлөн байгуулагдсан хуулийн этгээд /хуулийн этгээдүүд/-ийн дүрэм болон бүртгэлийн гэрчилгээ;

15.8.6. компани нэгдэх буюу өөрчлөх хэлбэрээр өөрчлөн зохион байгуулагдаж байгаа тохиолдолд нэгдэх буюу өөрчлөх тухай шийдвэр, хуваах буюу тусгаарлах хэлбэрээр өөрчлөн зохион байгуулагдаж байгаа тохиолдолд хуваах баланс;

15.8.7. бүртгэлийн хураамж төлсөн баримт.

15.9. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаагаа явуулдаг гадаадын хуулийн этгээд, түүний салбар буюу төлөөлөгчийн газар нь бүртгэх байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй. Бүртгэх байгууллага нь тэдгээрийг бүртгэх журмыг энэ хуульд заасан компанийг бүртгэх журамтай нийцүүлэн гаргана.

15.10. Компани улсын бүртгэлд бүртгүүлснээр байгуулагдсанд тооцогдож дүрэмд заасан үйл ажиллагаа явуулах эрхтэй.

***/Дээрхи 15 дугаар зүйлийг 2003 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд энэ хуулийг 2003 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөнө/***

**16 дугаар зүйл. Компанийн дүрэм**

16.1. Компанийн дүрэм нь түүний үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг мөн.

16.2. Компанийн дүрэмд дараахь зүйлийг заавал тусгана:

16.2.1. компанийн бүрэн болон товчилсон оноосон нэр, түүний хэлбэрийг тодорхойлсон товчилсон ялгах тэмдэглэгээ;

16.2.2. компанийн оршин байгаа газрын хаяг;
16.2.3. компанийн зарласан энгийн хувьцааны тоо;
16.2.4. дүрмээр давуу эрхийн хувьцааг зарласан нөхцөлд давуу эрхийн хувьцааны зарласан тоо, түүний эзэмшигчийн эрх;

16.2.5. хэрэв төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо;

16.2.6. хувь нийлүүлэгчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл болон хянан шалгах зөвлөл /хянан шалгагчдын/-ийн энэ хуулиар тодорхойлсноос бусад бүрэн эрх;

16.2.7. компанийн үйл ажиллагааны чиглэл;
16.2.8. дүрэмд тусгахаар энэ хуульд заасан бусад зүйл.

16.3. Компанийн дүрэмд Иргэний хууль болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөөгүй зүйлийг тусгаж болно.

16.4. Компани нь хувь нийлүүлэгчийн шаардлагаар компанийн дүрэм, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийг түүнд танилцуулах үүрэгтэй.

**17 дугаар зүйл. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах, бүртгэх**

17.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцсон, энэ асуудлаар саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн саналын дийлэнх олонхоор батална.

17.2. Компанийн дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлт, дүрмийн шинэчилсэн найруулга нь хувь нийлүүлэгчдийн эрх ашгийг хөндсөн тохиолдолд эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтанд

оролцоогүй хувь нийлүүлэгчид энэ хуулийн 54, 55 дугаар зүйлд заасан журмын дагуу эзэмшиж байгаа хувьцаагаа компанид эргүүлэн худалдахыг шаардах эрхтэй.

17.3. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгэхэд дараахь баримт бичгийн бүрдүүлнэ:

17.3.1. компанийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгүүлэх тухай компанийн эрх бүхий этгээдийн гарын үсэг бүхий өргөдөл;

17.3.2. компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр, орж байгаа өөрчлөлт нэмэлт, эсхүл шинэчилсэн найруулгын бүрэн эхийн хамтаар;

17.3.3. компанийн дүрмийн хуулбар, улсын бүртгэлийн гэрчилгээ;
17.3.4. бүртгэлийн хураамж төлсөн баримт.

17.4. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрмийг шинэчлэн найруулах тухай шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногийн дотор хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

17.5. Бүртгэх байгууллага энэ хуулийн 17.3.-т заасан баримтыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгэх, эсхүл бүртгэхээс татгалзсан үндэслэл бүхий шийдвэр гаргана.

17.6. Компанийн дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлт болон шинэчилсэн найруулгыг энэ хуулийн 17.3.-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд бүртгэхээс татгалзана.

17.7. Бүртгэх байгууллага компанийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгэхээс татгалзсан тухай шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногийн дотор татгалзах үндэслэлийг тусгасан мэдэгдлийг өргөдөлд заасан шуудангийн хаягаар илгээнэ. Бүртгэх байгууллагын энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл компани шүүхэд гомдол гаргаж болно.

17.8. Компанийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, шинэчлэн найруулсан дүрэм нь улсын бүртгэлд бүртгэснээр хүчин төгөлдөр болно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах, өрийг хувьцаагаар солих

**18 дугаар зүйл. Компанийг өөрчлөн байгуулах**

18.1. Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр компанийг энэ хуульд заасан журмын дагуу нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулж болно.

18.2. Хуульд заасан тохиолдолд шүүх компанийг хуваах, тусгаарлах шийдвэр гаргаж болно.

18.3. Нэгдэхээс бусад хэлбэрээр өөрчлөн байгуулагдаж байгаа нөхцөлд шинээр бий болж байгаа компанийг улсын бүртгэлд бүртгэснээр компани өөрчлөн байгуулсанд тооцно.

18.4. Нэгдэх хэлбэрээр өөрчлөн байгуулагдаж байгаа тохиолдолд нэгдэж байгаа компанийг улсын бүртгэлээс хасч нэгтгэсэн компанийн дүрэмд хэрэв өөрчлөлт орсон бол түүнийг улсын бүртгэлд бүртгэснээр тэдгээрийг өөрчлөн байгуулагдсанд тооцно.

18.5. Өөрчлөн байгуулах тухай шийдвэр гарснаас хойш ажлын 15 хоногийн дотор өөрчлөн байгуулагдсан компани нь зээлдүүлэгч болон бусад харилцагчдад өөрчлөн байгуулагдсан тухайгаа бичгээр мэдэгдэх бөгөөд мэдэгдэлд дараахь зүйлийг тусгана:

18.5.1. өөрчлөн байгуулсан арга хэлбэр;
18.5.2. өөрчлөн байгуулагдсан болон өөрчлөн байгуулалтын үр дүнд шинээр үүссэн компани тус бүрийн байршил болон оноосон нэр;

18.5.3. өөрчлөн байгуулах тухай шийдвэр гарсан огноо;

18.5.4. хуваах болон тусгаарлах хэлбэрээр өөрчлөн байгуулж байгаа тохиолдолд хуваах баланс.

18.6. Хувьцаат компани нь өөрчлөн байгуулагдах, татан буулгах тухай шийдвэр гаргаснаас хойш энэ тухайгаа Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржэд ажлын 3 хоногийн дотор мэдэгдэнэ.
*/Энэ хэсэгт 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

**19 дүгээр зүйл. Компаниуд нийлэх**

19.1. Хоёр буюу хэд хэдэн компанийн үйл ажиллагааг зогсоож, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг шинээр бий болсон компанид шилжүүлэхийг компаниуд нийлэх гэнэ.

19.2. Нийлж байгаа компани тус бүрийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь компанийг нийлэх замаар өөрчлөн байгуулах тухай шийдвэрийн төсөл болон өөрчлөн байгуулах нөхцөл, журмыг тодорхойлсон гэрээ, шинэ компанийн дүрэм, компани тус бүрийн үнэт цаасыг шинэ компанийн үнэт цаас буюу эд хөрөнгөд хөрвүүлэх журмыг тодорхойлсон саналаа компани тус бүрийн хувь нийлүүлэгчдийн хуралд оруулж шийдвэрлүүлнэ.

19.3. Компаниуд нийлэх тухай шийдвэр, гэрээг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн саналын дийлэнх олонхоор батална.

19.4. Гэрээнд шинээр үүссэн компанийн хувь нийлүүлэгчдийн хурал хуралдах хугацаа, товыг заана. Энэ хурлаар компанийн дүрмийг баталж, хэрэв төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол түүний гишүүдийг сонгоно. Хуралд оролцож байгаа хувь нийлүүлэгчдийн саналын эрх нь нийлэх гэрээгээр тодорхойлсон хөрвөсөн саналын эрхтэй тэнцүү байна.

**20 дугаар зүйл. Компани нэгдэх**

20.1. Компанийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг өөр компанид шилжүүлэхийг компани нэгдэх гэнэ.

20.2. Нэгдэж байгаа болон нэгтгэж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөл /хэрэв байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь компани нэгдэх тухай шийдвэрийн төсөл болон нэгдэх гэрээг компани тус бүрийн хувь нийлүүлэгчдийн хуралд оруулж шийдвэрлүүлнэ. Нэгдэх гэрээнд нэгдэх нөхцөл, журмыг тодорхойлохоос гадна нэгдэж байгаа компанийн үнэт цаас, нэгтгэж байгаа компанийн үнэт цаас, бусад хөрөнгөнд хөрвөх журмыг тусгасан байна.

20.3. Компанийг нэгдэх замаар өөрчлөн байгуулах тухай шийдвэрийг хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн саналын дийлэнх олонхоор гаргана.

20.4. Нэгдэж байгаа компанийн нийт энгийн хувьцааны 75-аас илүү хувийг эзэмшиж байгаа бөгөөд нэгдсэнээр компанийн дүрэмд өөрчлөлт орох шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд нэгтгэж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчид/-ийн хурлаар нэгдэх тухай шийдвэр гаргаж, нэгдэх журмыг баталж болно.

**21 дүгээр зүйл. Компанийг хуваах**

21.1. Компанийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг шинээр үүсэх 2 буюу түүнээс дээш компанид бүрэн шилжүүлэхийг компанийг хуваах гэнэ. Компанийг хуваах тухай шийдвэрт өөрөөр заагаагүй бол хуваагдаж байгаа компанийн энгийн хувьцаа эзэмшигчид нь компанийн хөрөнгийн хуваагдсан хэмжээтэй хувь тэнцүүлэн шинээр бий болсон компани тус бүрийн энгийн хувьцааны эзэмшигч болно.

*/Энэ хэсэгт 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

21.2. Компанийг хуваах замаар өөрчлөн байгуулах, шинэ компани байгуулах, хуваах балансыг батлах асуудал болон тухайн компанийн үнэт цаасыг шинээр байгуулагдсан компанийн үнэт цаас буюу эд хөрөнгөд хөрвүүлэх журмыг хуваагдаж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ хувь нийлүүлэгчдийн хуралд оруулж хуралд оролцогчдын саналын дийлэнх олонхоор шийдвэрлүүлнэ.

21.3. Шинээр байгуулагдсан компанийн хувь нийлүүлэгчдийн хурлаар компанийн дүрмийг баталж, хэрэв төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол түүний гишүүдийг сонгоно.

Энэ хурлыг хуралдуулах тусгайлсан журмыг хуваах замаар өөрчлөн байгуулах тухай шийдвэрт заана.

21.4. Компанийг хуваахад түүний эрх, үүрэг шинээр байгуулагдсан компаниудад хуваах балансын дагуу шилжинэ.Компанийг хуваах тухай гэрээнд өөрөөр заагаагүй бол шинээр үүссэн компани бүр бусад компанийнхаа өмнөөс давхар хариуцлага хүлээнэ.

**22 дугаар зүйл. Компанийг тусгаарлах**

22.1. Компанийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр түүний зарим эрх, үүрэг, хариуцлагыг шинээр байгуулагдсан компанид шилжүүлэхийг компанийг тусгаарлах гэнэ. Компанийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулахад өөрчлөн байгуулагдаж байгаа компани нь шинээр байгуулагдсан компанийн хувьцаа эзэмшигч байна.
*/Энэ хэсэгт 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

22.2. Компанийг тусгаарлах нөхцөл, журам, хуваах балансыг батлах болон шинэ компани байгуулах тухай шийдвэрийг өөрчлөн байгуулагдаж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ гаргана.

22.3. Шинээр байгуулагдсан компанийн хувь нийлүүлэгчдийн хурал нь энэ байгуулагдсан компанийн дүрмийг баталж, хэрэв төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол түүний гишүүдийг сонгоно.

22.4. Компанийг тусгаарлахад өөрчлөн байгуулагдаж байгаа компани нь өөрийн бүх өрийг хариуцна. Өөрчлөн байгуулагдаж байгаа компанийн өмнөөс түүний өрийг шинээр бий болж байгаа компаниар төлүүлэхийг хуваах балансаар тогтоож болно. Энэ тохиолдолд өөрчлөн байгуулагдаж байгаа компани нь шинээр байгуулагдсан компанид шилжүүлсэн үүргээ хамтран хүлээнэ.

22.5. Энэ хуулийн долдугаар бүлэгт заасныг үндэслэн компанийг тусгаарласны дараа шинээр байгуулагдсан компаниас гаргасан үнэт цаасыг бүгдийг нь, эсхүл түүний зарим хэсгийг ногдол ашиг хэлбэрээр өөрчлөн байгуулагдсан компанийн хувьцаа эзэмшигчид шилжүүлж болно.

**23 дугаар зүйл. Компанийг өөрчлөх**

23.1. Хувьцаат компани нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, хязгаарлагдмал хариуцлагатай компани нь хувьцаат компани болох замаар компанийг өөрчилж болно. Энэ өөрчлөх төслийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ боловсруулан хувь нийлүүлэгчдийн хуралд оруулан уг асуудлаар саналын эрхтэй хуралд оролцогчдын саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.

23.2. Компанийг өөрчлөх төсөлд өөрчлөх зорилго, нөхцөл, журам, хувьцааг харилцан хөрвүүлэх арга, тооцоо, өөрчлөлт оруулах хугацаа, хувь нийлүүлэгчдийн хурлыг хуралдуулах хугацаа зэргийг тусгасан байна.

23.3. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтөөр үүссэн компанийн хувь нийлүүлэгчдийн хурлыг хуульд заасан журмын дагуу зарлан хуралдуулж компанийн дүрэм, удирдах байгууллагыг шинэчлэн баталж болох бөгөөд үүнийг компанийг өөрчлөх төсөлд зааж өгнө.

23.4. Компанийг өөрчлөхөд түүний эрх, үүрэг шинээр бий болж байгаа компанид шилжинэ.

23.5. Компанийг өөрчлөх тохиолдолд холбогдох өөрчлөлтийг компанийн оноосон нэр болон дүрэмд тусгана.

**24 дүгээр зүйл. Компани өөрчлөн байгуулсантай холбогдсон хувь нийлүүлэгчийн эрх**

24.1. Нийлэх, нэгдэх буюу өөрчлөх замаар өөрчлөн байгуулагдаж байгаа компанийн саналын эрхтэй хувь нийлүүлэгч нь өөрчлөн байгуулахын эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтанд оролцоогүй бол энэ хуулийн 54, 55 дугаар зүйлд заасан журмын дагуу өөрийн эзэмшиж байгаа хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах эрхтэй.

24.2. Эргүүлэн худалдахаар тохиролцсон хувь нийлүүлэгчийн хувьцааг компанийг өөрчлөн байгуулах шийдвэрийн дагуу хөрвүүлж үл болно. Энэ тохиолдолд тухайн хувь нийлүүлэгч нь өөрийн хувьцаагаа компанид эргүүлэн авахыг шаардахаас бусад хувьцаа эзэмшихтэй холбогдсон эрхээ алдана.

24.3. Өөрийн эзэмшилд байгаа хувьцаагаа эргүүлэн авахыг компаниас шаардаагүй хувь нийлүүлэгчдийн хувьцааг компанийг өөрчлөн байгуулах шийдвэрийн дагуу хөрвүүлнэ.

**25 дугаар зүйл. Компанийн өрийг хувьцаагаар солих**

25.1. Компанийн хувьцаанаас бусад үнэт цаас болон өрийг хувьцаагаар сольж болох бөгөөд үүнийг өрийг хувьцаагаар солих гэнэ.

25.2. Зээлдүүлэгч болон бусад харилцагчтай байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол компанийн өрийг хувьцаагаар солиход хувьцаа авах тухайн зээлдүүлэгч, харилцагчийн зөвшөөрлийг авсан байна.

25.3. Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь компанийн өрийг хувьцаагаар солих төсөл боловсруулан хувь нийлүүлэгчдийн хуралд оруулж, уг асуудлаар саналын эрхтэй хуралд оролцогчдын дийлэнх олонхийн саналаар шийдвэрлүүлнэ.

25.4. Өрийг хувьцаагаар солих тухай төсөлд солигдох өр, гаргах хувьцааны хэмжээ, үнэ, зорилго, хэрэгжүүлэх нөхцөл, журам, компанийн дүрэмд оруулах өөрчлөлт зэргийг зааж өгсөн байна.

25.5. Хувьцаа, худалдан авах эрхийн бичиг буюу хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэдгээрийн хөрвөх нөхцөлийн дагуу хөрвүүлэхийг компанийн өрийг хувьцаагаар сольсонд тооцохгүй.

25.6. Компанийн өрийг хувьцаагаар солих асуудлаар эсрэг саналтай байсан буюу санал хураалтанд оролцоогүй хувь нийлүүлэгч хувьцаа авахад оролцох эрхтэй.

**26 дугаар зүйл. Компанийг татан буулгах**

26.1. Компанийг хувь нийлүүлэгчдийн хурлын болон шүүхийн шийдвэрээр Иргэний хууль, энэ хууль болон бусад хуульд заасан үндэслэлээр татан буулгана.

26.2. Шүүх компанийг дор дурдсан үндэслэлээр татан буулгана:

26.2.1. дампуурсан;
26.2.2. нэг ч гишүүн үлдээгүй;
26.2.3. хуульд заасан бусад үндэслэл.

26.3. Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр татан буугдаж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь компанийг татан буулгах комисс томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсаны дараагаар компанид үлдэж байгаа эд хөрөнгийг хувь нийлүүлэгчдэд хуваарилах журам зэргийг тусгасан татан буулгах төслийг хувь нийлүүлэгчдийн хуралд оруулж, хуралд оролцогчдын саналын дийлэнх олонхоор шийдвэрлүүлнэ.

26.4. Татан буулгах комисс томилсоноор тухайн компанийн гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх дуусгавар болж татан буулгах комисст шилжих бөгөөд уг комисс нь татан буугдаж байгаа компанийн нэрийн өмнөөс шүүх хуралд төлөөлөн оролцоно.

26.5. Татан буулгах комисс үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас тухайн компанид, эсхүл зээлдүүлэгчид ямар нэг хохирол учруулсан бол уг хохирлыг хуульд заасан журмын дагуу хариуцна.

**27 дугаар зүйл. Компанийг татан буулгахад өр төлбөрийг барагдуулах журам**

27.1. Компанийг татан буулгах үед өр төлбөрийг барагдуулахдаа Иргэний хууль, энэ хууль болон бусад хуулийн заалтыг мөрдөнө.

27.2. Татан буулгах комисс нь компанийг татан буулгах болон нэхэмжлэл гаргах журам, хугацааг нийтэд мэдээлнэ. Нэхэмжлэл гаргах хугацаа нь татан буулгах тухайг нийтэд мэдээлснээс хойш 2 сараас багагүй, 6 сараас ихгүй байна.

27.3. Татан буулгах комисс нь компанийг татан буулгах, нэхэмжлэл гаргах журам, хугацааг зээлдүүлэгчдэд бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

27.4. Хэрвээ татан буулгах тухай шийдвэр гаргах үед компани нь ямар нэгэн өргүй бол компанийг татан буулгах мэдэгдлийг нийтэд мэдээлэхгүйгээр түүнийг татан буулгаж болно. Энэ тохиолдолд компанийн эд хөрөнгийг энэ хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу хувь нийлүүлэгчдэд хуваарилна.

27.5. Нэхэмжлэл гаргах хугацаа дууссанаар татан буулгах комисс нь татан буугдаж байгаа компанийн эд хөрөнгийн тухай мэдээ, зээлдүүлэгчдийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг хэрхэн шийдвэрлэх дүнг агуулсан татан буулгах түр балансыг гаргах бөгөөд уг балансыг компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал / батална.

27.6. Татан буулгах комисс нь нэхэмжлэлийг хэрхэн барагдуулах тухайгаа тэдэнд бичгээр мэдэгдэх бөгөөд зээлдүүлэгч нь энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл татан буулгалтын балансыг батлахаас өмнө шүүхэд гомдол гаргаж болно.

27.7. Хэрэв татан буугдаж байгаа компанийн мөнгөн хөрөнгө нь нэхэмжлэлийг барагдуулахад хангалтгүй бол татан буулгах комисс нь компанийн бусад эд хөрөнгийг худалдана. Хэрэв эдгээр эд хөрөнгийг худалдах нь энэ хуулийн арван гуравдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тохиолдолд шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх журмын дагуу дуудлага худалдаагаар худалдана.

27.8. Татан буугдаж байгаа компанийн зээлдүүлэгчдийн өр төлбөрийг татан буулгах комисс нь татан буулгах балансыг баталсан өдрөөс эхлэн тус балансын дагуу Иргэний хууль болон энэ хуульд заасан дараалын дагуу барагдуулна.

27.9. Татан буулгах комисс нь өр төлбөрийг барагдуулсны дараа дуусгалтын баланс гаргана. Балансыг зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг хэрхэн барагдуулсан тухай мэдэгдэл явуулснаас хойш ажлын 30 ба түүнээс дээш хоногийн дараа гаргана.

27.10. Дуусгалтын баланс гаргаснаас хойш шүүх тусгайлан шийдвэрлээгүй бол гаргасан аливаа нэхэмжлэлийг хүлээн авахгүй.

**28 дугаар зүйл. Татан буугдаж байгаа компанийн эд хөрөнгийг хувь нийлүүлэгчдэд хуваарилах**

28.1. Татан буулгах комисс нь зээлдүүлэгчдийн өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогыг дараахь дараалын дагуу хувьцаа эзэмшигчдэд хуваарилна:

28.1.1. давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг болон давуу эрхийн хувьцааны татан буулгалтын үнэ, түүнчлэн энэ хуулийн 54, 55 дугаар зүйлд заасны дагуу эргүүлэн авах давуу эрхийн хувьцааны төлбөр;

28.1.2. энэ хуулийн 54, 55 дугаар зүйлд заасны дагуу эргүүлэн худалдаж авах энгийн хувьцааны төлбөр;

28.1.3. үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогыг компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн дунд тэдгээрийн эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүүлэн.

**29 дүгээр зүйл. Компанийг татан буулгаж дуусгах**

29.1. Компанийн бүх эд хөрөнгийг хуваарилсны дараа татан буулгах комисс нь компанийг татан буулгах замаар үйл ажиллагаа дуусгавар болсон тухай бүртгэх байгууллагад мэдэгдэж, татан буулгах балансын нэг хувийг бүртгэх байгууллагад хүргүүлнэ.

29.2. Бүртгэх байгууллага компанийг улсын бүртгэлээс хассанаар татан буугдсанд тооцно. Энэ тухай бүртгэх байгууллага нийтэд мэдээлнэ.

**30 дугаар зүйл. Компанийн үйл ажиллагааг дуусгавар болгох**

30.1. Бүртгэх байгууллага дараахь баримт бичгийг үндэслэн компанийн үйл ажиллагаа дуусгавар болсныг бүртгэнэ.

30.1.1. компанийг татан буулгах замаар дуусгавар болгож байгаа тохиолдолд компанийг татан буулгах тухай хувь нийлүүлэгчдийн хурлын буюу шүүхийн шийдвэр, дуусгалтын балансын хуулбар;

30.1.2. компанийн үйл ажиллагаа нь нэгдэх, нийлэх, хуваах, өөрчлөгдсөний улмаас дуусгавар болсон тохиолдолд өөрчлөн байгуулах тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр;

30.1.3. хуваах замаар өөрчлөн зохион байгуулагдсаны улмаас компанийн үйл ажиллагаа дуусгавар болсон тохиолдолд хуваах тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр, хуваах баланс;

30.1.4. компанийн дүрэм болон бүртгэлийн гэрчилгээ.

30.2. Компанийн үйл ажиллагаа нь нэгдэх, нийлэх, өөрчлөгдсөний улмаас дуусгавар болсон тухай мэдэгдэлд дуусгавар болсон компанийн эрх, үүргийг шилжүүлэн авсан хуулийн этгээдийн нэрийг бичнэ. Компанийн үйл ажиллагаа нь хуваагдсаны улмаас дуусгавар болсон тухай мэдэгдэлд дуусгавар болсон компанийн эрх, үүргийг хуваах балансын дагуу шилжүүлэн авсан компани тус бүрийн нэрийг бичнэ.

30.3. Дараахь тохиолдолд бүртгэх байгууллага, эсхүл хувь нийлүүлэгч, эсхүл зээлдүүлэгч компанийг татан буулгахаар шүүхэд хандаж болно:

30.3.1. компанийн үйл ажиллагаа явуулах дүрэмд заасан хугацаа дуусгавар болсон;

30.3.2. тусгай зөвшөөрөл шаардсан үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан бөгөөд тус үйл ажиллагаа нь компанийн дүрмээр зөвшөөрөгдсөн цорын ганц үйл ажиллагаа байсан;

30.3.3. компанийг бүртгэх буюу үйл ажиллагаагаа эрхлэх явцад хуулийн ноцтой зөрчил гарсан нь нөхөж болшгүй буюу эдгээр зөрчлүүдийн тухай бичгээр мэдэгдэл хүлээж авсан ч компани нь тэдгээрийг арилгаж чадаагүй байгаа.

***/Дээрхи 30 дугаар зүйлийг 2003 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд энэ хуулийг 2003 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөнө/***

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, компанийн хувьцаа, бусад үнэт цаас

**31 дүгээр зүйл. Компанийн өөрийн хөрөнгө**

31.1. Компанийн балансанд тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн нийт дүнгээс компанийн өр төлбөрийг хасаж үлдсэн хэсгийг компанийн өөрийн хөрөнгө буюу хувь нийлүүлэгчдийн хөрөнгө гэнэ.

**32 дугаар зүйл. Компанийн өөрийн хөрөнгийн доод хэмжээ**

32.1. Хувьцаат компанийг бүртгэх өдөр түүний өөрийн хөрөнгө нь 10 сая төгрөг ба түүнээс дээш байна. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийг бүртгэх өдөр түүний өөрийн хөрөнгө нь нэг сая төгрөг ба түүнээс дээш байна.

32.2. Хоёр жил дараалан жилийн балансн тусгагдсан компанийн өөрийн хөрөнгө нь энэ хуулийн 32.1. -д заасан доод хэмжээнээс доогуур байх нөхцөлд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь компанийг татан буулгах тухай асуудлыг хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэнэ. Хурал нь компанийг татан буулгах асуудлыг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд компанийн нийт өрийн 10-аас илүү хувийг нэхэмжлэх эрхтэй зээлдүүлэгч нь компанийг татан буулгахаар шүүхэд хандаж болно.

**33 дугаар зүйл. Компанийн хувьцаа**

33.1. Үнэт цаасны тухай хуульд цаасны дагуу хувьцаа нь компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг эрхийг гэрчилнэ.

33.2. Хувьцаа нь энгийн ба давуу эрхийн гэсэн хэлбэртэй байна.

33.3. Компани нь энгийн хувьцааг заавал гаргах үүрэг хүлээнэ.Компани нь давуу эрхийн хувьцааг гаргаж болно.

33.4. Хувьцаа нь компанийн дүрмээр тогтоосон нэрлэсэн үнэтэй байж болно. Нэрлэсэн үнэтэй хувьцааг түүнээс доош үнээр гаргахыг хориглоно.

33.5. Хувьцаа бүр саналын нэг эрхтэй байна.

33.6. Хувьцаа хуваагдахгүй бөгөөд эзэмшигчийн нэртэй байна.

**34 дүгээр зүйл. Компанийн зарласан болон гаргасан хувьцаа**

34.1. Компаниас гаргах энгийн болон давуу эрхийн хувьцааны тоог компанийн дүрмээр тогтоох бөгөөд үүнийг зарласан хувьцаа гэнэ.

34.2. Зарласан хувьцаанаас хувь нийлүүлэгчдийн худалдан авч эзэмшсэн хэсгийг эргэлтэд гаргасан хувьцаа гэнэ.Хэрэв компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцааны төрөл тус бүрээс гаргах хувьцааны тоо, гаргах хугацаа, нөхцөлийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал / тогтооно. Гаргасан хувьцааны тоог компанийн балансанд төрөл тус бүрээр нь тусгана.

34.3. Аль нэг төрлийн зарласан хувьцааны тоо нь тухайн төрлийн хувьцааны гаргасан тоо болон тухайн хувьцаанд хөрвөх үнэт цаасыг хөрвүүлэхэд шаардагдах хувьцааны тооны нийлбэрээс багагүй байна.

34.4. Компаниас гаргасан хувьцаа нь тэдгээрийг компани худалдан авах буюу эргүүлэн авах, эсхүл бусад төрлийн үнэт цаас, эд хөрөнгөд хөрвүүлэх хүртэл эргэлтэнд байна.

34.5..Компани өөрийн хувьцааг худалдан авах буюу эргүүлж авбал эдгээр хувьцааг зарласан боловч гаргаагүй хувьцаа гэж тооцно. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компани нь эдгээр хувьцааг дахин гаргаж болно.

**35 дугаар зүйл. Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн эрх**

35.1. Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараахь эрх эдэлнэ:

35.1.1. хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;

35.1.2. давуу эрхийн хувьцааны ногдол ашиг төлсөний дараагаар компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/-өөс тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах;

35.1.3. компанийг татан буулгах үед энэ хуулийн 28 дугаар зүйлд тогтоосон журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх.

35.1.4. хувьцаат компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь энэ хуулийн 39 дүгээр зүйл болон компанийн дүрэмд заасны дагуу компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.

35.1.5. компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хязгаарлагдмал хариуцлагатай компанийн энгийн хувьцаа эзэмшигчид нь хувьцаанд хамаарах бусад үнэт цаасыг энэ зүйлд заасан бусад журмын дагуу тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдэлнэ.

35.2. Компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчийн эзэмшиж болох энгийн хувьцааны тоог хязгаарлаж болохгүй.

35.3. Энгийн хувьцааг компанийн давуу эрхийн хувьцаа болон бусад үнэт цаасанд хөрвүүлж үл болно.

35.4. Хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэх зарим асуудлаар энгийн хувьцаа эзэмшигчийн санал өгөх эрхийг энэ хууль болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр хязгаарлаж болно.

**36 дугаар зүйл. Компанийн давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн эрх**

36.1. Бүх төрлийн давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь дараахь эрх эдэлнэ:

36.1.1. эрх бүхий байгууллагаас тогтоосон давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг тэргүүн ээлжинд авах;

36.1.2. энэ хууль, компанийн дүрэм болон тухайн төрлийн давуу эрхийн хувьцаа гаргах тухай шийдвэрт заасан асуудлаар хувь нийлүүлэгчдийн хуралд саналын эрхтэй оролцох;

36.1.3. компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсан орлогоос хуримтлагдсан ногдол ашиг болон эзэмшиж байгаа хувьцааны татан буулгалтын үнийг авах.

36.2. Компанийн дүрэм, эсхүл тухайн төрлийн давуу эрхийн хувьцаа гаргах тухай шийдвэрт дор дурдсан зүйлийг тусгана:

36.2.1. татан буулгах үед түүнд төлөх төлбөр, төлөх журам, дэс дараалал;

36.2.2. хувь нийлүүлэгчдийн хуралд саналын эрхтэй оролцох нөхцөл, давуу эрхийн нэг хувьцаанд ногдох саналын тоо;

36.2.3.давуу эрхийн хувьцааг энгийн хувьцаанд хөрвүүлэх бол түүний нөхцөл;

36.2.4. давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшилд байгаа давуу эрхийн хувьцаагаа компанид эргүүлэн авахыг шаардах нөхцөл.

36.3. Компани нь давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг бүрэн төлсөн болон эргүүлэн авах үүрэг бүхий давуу эрхийн хувьцааг авсаны дараа энгийн хувьцааг эргүүлэн авах буюу худалдан авах, түүнд ногдол ашиг төлөх эрхтэй болно.

36.4. Энэ хуулийн 48.3.-т заасан нөхцөл үүсээгүй бол компани нь давуу эрхийн хувьцаанд ногдох ногдол ашгийг дүрэмд заасан хэмжээ болон хугацаанд төлнө.

36.5. Компанийг татан буулгах тохиолдолд энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдох хөрөнгийг олгохоос өмнө дараалын дагуу давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд уг хувьцааны татан буулгалтын үнэ, төлөгдөөгүй ногдол ашгийг төлнө.

36.6. Давуу эрхийн хувьцаа эзэмшигчид нь хувь нийлүүлэгчдийн хуралд дараахь тохиолдолд саналын эрхтэй оролцоно:

36.6.1. компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон дүрмийн шинэчилсэн найрууулгыг батлахдаа тэдгээрийн эрхийг хязгаарласан заалтыг оруулж байвал;

36.6.2. компанийг өөрчлөн байгуулах явцад давуу эрхийн хувьцааг энгийн хувьцаа, бусад төрлийн үнэт цаас болон бусад хөрөнгөнд хөрвүүлж байвал.

36.7. Энэ хуулийн 36.6.-д заасны дагуу давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй оролцож байгаа хувь нийлүүлэгчдийн хурлын уг асуудлаарх шийдвэрийг компанийн дүрэмд дээгүүр тогтоогоогүй бол зөвхөн давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор гаргана.

36.8. Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох хуралд давуу эрхтэй хувьцаа эзэмшигчдийг дараахь нөхцөлд саналын эрхтэй оролцуулахаар компанийн дүрэмд зааж болно:

36.8.1. компанийн дүрэмд энгийн хувьцаанд хөрвөх давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн төлөөлөн удирдах зөвлөлд өөрийн төлөөлөгчийг оруулж болохоор заасан бол;

36.8.2. давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг хугацаанд нь төлөөгүй бол.

**37 дугаар зүйл. Алтан хувьцаа**

37.1. Засгийн газар төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмч давамгайлсан компанийн төрд ногдох хэсгийг бүхэлд нь хувьчлах тухай шийдвэр гаргахдаа тодорхой хугацаанд энэ хуулийн 37.2.-т заасан асуудлаар компанийн хувь нийлүүлэгчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн болон гүйцэтгэх удирдлагын шийдвэрт хориг тавих эрхтэй, ногдол ашиг авдаггүй, өөр ямар нэг эрхгүй алтан хувьцааг гаргахаар зааж болно.

37.2. Алтан хувьцаатай компанийн хувь нийлүүлэгчдийн хурал болон төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагаас дор дурдсан асуудлаар гаргасан шийдвэр нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн эрх ашигт харшилсан тохиолдолд хориг тавина:

37.2.1. хувьчлахаас өмнө эрхэлж байсан үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх;
37.2.2. компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах;
37.2.3. их хэмжээний хэлцэл байгуулах;
**37.2.4. бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох, өөрчлөх.**

37.3. Хориг тавих тухай шийдвэрийг Засгийн газар гаргах бөгөөд энэ шийдвэрт хориг тавьж байгаа үндэслэлийг заана.

**37.4. Энэ хуулийн 37.2.-т заасан асуудлаар компанийн гаргасан шийдвэр нь Засгийн газар батламжилснаар хүчин төгөлдөр болно.**

37.5. Алтан хувьцааг бусдад шилжүүлж үл болно.

**37.6. Хугацаа дуусмагц алтан хувьцаа нь хүчингүй болно. Хугацааг дахин сунгаж үл болно.**

**38 дугаар зүйл. Хувьцаанд хамаарах үнэт цаас**

38.1. Энгийн хувьцааг худалдан авах эрхийн бичиг болон хувьцаанд хөрвөх үнэт цаас, опционыг хувьцаанд хамааруулах бөгөөд тэдгээрийг гаргах, худалдах журмыг компанийн дүрмээр тодорхойлно.

**39 дүгээр зүйл. Хувьцаа тэргүүн ээлжинд худалдан авах эрх**

39.1. Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь нэмж гаргаж байгаа энгийн хувьцааг өөрийн эзэмшиж байгаа энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тодорхой нөхцөлөөр тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.

39.2. Хувьцааг нэмж гаргах шийдвэр гаргах үед энгийн хувьцаа эзэмшигч бүрт гаргаж байгаа хувьцааны тоо, үнэ, хувьцаа эзэмшигч бүрийн худалдан авч болох хувьцааны тоо, төлбөр хийх хугацаа, журам зэргийг заасан мэдэгдлийг хувь нийлүүлэгчдийн хурлын зар хүргэдэг журмаар хүргүүлнэ. Хувьцаа эзэмшигч тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр хувьцааг худалдан авах тухай саналаа шийдвэр гарснаас хойш ажлын 30 хоногийн дотор ирүүлнэ.

39.3. Тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр хувьцааг худалдан авах үнэ нь тухайн хувьцааны зах зээлийн үнийн 90 хувь ба түүнээс доош байж болохгүй.

*/Энэ хэсэгт 2000 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/.*

39.4. Тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр хувьцаа худалдан авах хувь нийлүүлэгч нь тогтоосон хугацаанд нэр, хаяг, худалдан авах хувьцааны тоо, үнийг төлсөн баримтыг компанид ирүүлснээр тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр хувьцааг худалдан авсанд тооцно.

39.5. Хувьцаа эзэмшигч нь хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ бүхэлд нь болон хэсэгчлэн хэрэгжүүлж болно.Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч нь энэ эрхээ бусад этгээдэд бүхэлд нь болон хэсэгчлэн шилжүүлж болно.

39.6. Хувьцаат компанийн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож байгаа тухайн асуудлаар саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн саналын дийлэнх олонхоор хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэж болно.

**40 дүгээр зүйл. Хувьцаанд хөрвөх үнэт цаас**

40.1. Компанийн давуу эрхийн хувьцаа, өрийн бичгийг тодорхой нөхцөлд тодорхой тооны энгийн хувьцаанд хөрвүүлэх болзолтойгоор гаргаж болно.

40.2. Давуу эрхийн хувьцаа, өрийн бичгийг энгийн хувьцаанд хөрвөх эрхтэйгээр гаргаж байгаа үед хувьцаанд хөрвөх үнэт цаасыг хамт гаргана.

40.3. Хувьцаанд хөрвөх үнэт цаасны бүрдүүлбэрт хөрвөх үнэт цаасны төрөл, хөрвөх энгийн хувьцааны тоо, хөрвөх үнэ, хугацаа зэрэг байна.

40.4. Хувьцаат компанийн гаргасан энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаасны хөрвөх үнэ нь тухайн энгийн хувьцааны зах зээлийн үнээс доогуур байж болохгүй .

40.5. Хувьцаанд хөрвөх үнэт цаасыг гаргаж байгаа үед энгийн хувьцаа эзэмшигчид нь өөрийн эзэмшилд байгаа энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн эдгээр үнэт цаасыг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.

**41 дүгээр зүйл. Опцион**

41.1. Компанийн дүрмээр зөвшөөрсөн тохиолдолд компани тодорхой тооны энгийн болон давуу эрхийн хувьцааг тогтоосон үнээр, заасан хугацаанд худалдан авах эрхийг баталгаажуулсан опцион гаргаж болно.

41.2. Опционы бүрдүүлбэрт нэгж опцион эзэмшигчийн худалдан авч болох хувьцааны тоо, төрөл, үнэ, эцсийн хугацааг заана.

41.3. Хувьцаат компанийн гаргасан энгийн хувьцаа худалдан авах опционы үнэ нь тухайн хувьцааны зах зээлийн үнээс доогуур байж болохгүй.

41.4. Энгийн хувьцаа худалдан авах опцион гаргаж байгаа үед энгийн хувьцаа эзэмшигчид нь өөрийн эзэмшилд байгаа энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн эдгээр үнэт цаасыг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.

**42 дугаар зүйл. Компанийн өрийн бичиг**

42.1. Компани өөрийн хөрөнгийн хэмжээгээр барьцаалан тодорхой хугацааны дараа тогтоосон хүү төлж, эргүүлэн авах нөхцөлтэйгээр өрийн бичиг гаргаж болно.

42.2. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол өрийн бичиг гаргах шийвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал / гаргана. Энэ шийдвэрт өрийн бичгийн хэмжээ, төрөл, хугацаа, гаргасан үнэ, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, эргүүлэн авах үнэ, бусад мэдээллийг заана.

42.3. Компани нь нэг удаа бүрэн төлөгдөх, эсхүл хэсэгчлэн төлөгдөх өрийн бичиг гаргаж болно.

42.4. Компанийн өрийн бичиг нь өөр компаниас тусгайлан гаргасан баталгаатай байж болно.

42.5. Компани гаргасан өрийн бичгээ төлөгдөх хугацаанаас нь өмнө эргүүлэн авч болно. Энэ тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал гаргана.

**43 дугаар зүйл. Үнэт цаас гаргах тухай шийдвэр**

43.1. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/ гаргана. Шийдвэрт үнэт цаасны төрөл, тоо, гаргах хугацаа, нөхцөлийг заана.

43.2. Компани зарласан энгийн хувьцааг бүхэлд нь, эсхүл хэсгийг нь гаргах үүрэгтэй. Давуу эрхийн хувьцааг зарласан хэмжээгээр нь, эсхүл хэсгийг нь гаргаж болохоос гадна тодорхой хугацаанд гаргахгүй байж болно.

43.3. Нийтэд худалдахаар гаргаж байгаа үнэт цаас болон хувьцаат компанийн нэмж гаргаж байгаа хувьцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлнэ.
*/Энэ хэсэгт 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

**44 дүгээр зүйл. Хувьцаа, бусад үнэт цаасны үнийг тогтоох**

44.1. Дор дурдсанаас бусад тохиолдолд хувьцаа, бусад үнэт цаасны үнийг энэ хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/ тогтооно:

44.1.1. хувьцаанд хөрвөх үнэт цаас болон опцион гаргах үед үнийг тогтоосон бол;

44.1.2. хувьцаа худалдаж авах эрхийн бичгээр хувьцааг худалдаж байгаа бол;

44.1.3. компани үүсгэн байгуулж байгаа үед үүсгэн байгуулах баримт бичигт хувьцааны үнийг тогтоосон бол;

44.1.4. хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөр тохиолдол заасан бол.

**45 дугаар зүйл. Үнэт цаасны төлбөр**

45.1. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол гаргасан үнэт цаасны төлбөрийг худалдан авч байгаа этгээд нь мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр хийж болно.

45.2. Компанийг үүсгэн байгуулахааар гаргасан хувьцааны төлбөрийг компанийг улсын бүртгэлд бүртгэхээс өмнө төлнө. Цаашид нэмж гаргах үнэт цаасны төлбөрийг тэдгээрийг худалдан авах үед бүрэн төлнө.

45.3. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол үнэт цаасны төлбөрийг доорх тохиолдолд мөнгөн бус хэлбэрээр хийж болно:

45.3.1. үүсгэн байгуулах үед хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийхийг энэ хуулийн 14.6-д заасны дагуу үүсгэн байгуулах баримт бичигт зөвшөөрсөн;

45.3.2. нэмж гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийж болохоор эрх бүхий байгууллагын шийдвэрт заасан;

45.4. Үүсгэн байгуулах үед хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийж байгаа бол түүний үнэлгээг үүсгэн байгуулах хурлаар санал нэгтэй батална.

45.5. Үнэт цаасыг нэмж гаргаж байгаа үед түүний төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийх үнэлгээг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/ эцэслэн шийдвэрлэнэ. Хувьцаат компанийн хувьд төлөөлөн удирдах зөвлөл үнэлгээний талаар шийдвэр гаргахдаа мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэс болгоно.

**46 дугаар зүйл. Үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл**

46.1. Компани нь үнэт цаас эзэмшигчдийнхээ бүртгэлийг хөтөлж, үнэт цаасыг биет байдлаар гаргасан бол түүнийг хадгалах ажлыг зохион байгуулах үүрэгтэй. Энэ үүргээ үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх авсан байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

46.2. Компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл нь тухайн үнэт цаас эзэмшигчийн овог, нэр, оршин суугаа хаяг, түүний эзэмшиж байгаа үнэт цаасны төрөл, хэмжээ болон үнэт цаасыг шилжүүлсэнтэй холбогдон шилжүүлэгдсэн үнэт цаасны хэмжээ /тоо/, шилжүүлсэн болон шилжүүлэн авсан этгээдийн овог, нэр зэргийг тусгасан байна.

46.3. Компанийн үнэт цаас эзэмшигч этгээд нь өөрийн нэр, оршин суугаа хаяг болон эзэмшилд байгаа үнэт цаасны хэмжээ /тоо/-г бүртгэл хөтлөх этгээдэд мэдээлэхийн зэрэгцээ эдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг цаг тухайд нь бүртгэл хөтлөх этгээдэд мэдэгдэх үүрэг хүлээнэ.

46.4. Компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл хөтлөх этгээд нь бүртгүүлсэн этгээдийн шаардсанаар түүний үнэт цаас эзэмших эрхийг бүртгэлээс хуулбар хийх замаар баталгаажуулах үүрэгтэй. Хуулбар нь үнэт цаасад хамаарахгүй.

46.5. Компани нь үнэт цаасыг биет бус хэлбэрээр гаргаж байгаа тохиолдолд эдгээр үнэт цаас эзэмшигчид тэдний эрхийг нотолсон баримт /сертификат/ олгож болно.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### Ногдол ашиг, компанийн өмчийг шилжүүлэх

**47 дугаар зүйл. Ногдол ашиг хуваарилах**

47.1. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал / гаргана. Энэ байгууллага нь ногдол ашиг хуваарилахдаа хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалт гаргах, бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож энэ талаар хувь нийлүүлэгчдэд мэдэгдэнэ.

47.2. Ногдол ашиг авах эрхтэй хувь нийлүүлэгчдийг тодорхойлохдоо хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьд ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргасан өдрөөр тасалбар болгон тодорхойлно.Харин хувьцаат компанийн хувьд энэ бүртгэлийн өдрийг шийдвэр гарсан өдрөөс хойш тусгайлан тогтоох бөгөөд энэ тухай нийт хувь нийлүүлэгчдэд яаралтай зарлан мэдэгдэнэ.

47.3. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.

47.4. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.

47.5. Бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэлх хугацаанд өөрийн эзэмшилд байсан хувьцааг бусдад шилжүүлсэн тохиолдолд ногдол ашиг авах эрх нь уг хувьцааны хуучин эзэмшигч этгээдэд үлдэнэ.

47.6. Хэрэв компани нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаандаа ногдол ашгаа төлөх үүрэгтэй. Ногдол ашгаа хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн нэхэмжлэлээр компани нь алданги төлөх бөгөөд үүнээс компанид учирсан хохирлыг компанийн гүйцэтгэх удирдлага хариуцна.

**48 дугаар зүйл. Ногдол ашиг хуваарилах нөхцөл**

48.1. Компани нь дор дурдсан тохиолдолд энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилна:

48.1.1. ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх;

48.1.2. ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан доод хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх;

48.1.3. компани нь эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.

48.2. Компани эргүүлэн авсан өөрийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй.

48.3. Компани нь дор дурдсан тохиолдолд давуу эрхийн хувьцаанд ногдол ашиг хуваарилна:

48.3.1. ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх;

48.3.2. компани нь эргүүлэн авах үүрэгтэй давуу эрхийн хувьцааг бүрэн авсан байх.

48.4. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь 25-аас дээш хувиар багассан тохиолдолд компани нь ногдол ашгийг шилжүүлсэн өдрөөс хойш ажлын 15 хоногийн дотор өөрийн зээлдүүлэгчдэд өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ.

48.5. Компани ногдол ашиг хуваарилаагүй тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл хувь нийлүүлэгчдийн ээлжит хуралд шалтгааныг тайлагнах үүрэг хүлээнэ.

**49 дүгээр зүйл. Компанийн эд хөрөнгийн захиран зарцуулалтад тавих хязгаарлалт**

49.1. Зээлдүүлэгчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах зорилгоор компанийн өөрийн хөрөнгө нь энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан хэмжээнээс бага болох, эсхүл компани төлбөрийн чадваргүй болохоор байвал компанийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг бусдад зах зээлийн үнээс доогуур үнээр худалдахыг хориглоно.

49.2. Энэ хуулийн 49.1.-г зөрчиж хийсэн хэлцэл шүүхийн шийдвэрээр хүчингүй болно.

## ДОЛДУГААР БҮЛЭГ

**Компани өөрийн үнэт цаасыг худалдан авах болон эргүүлэн авах**

**50 дугаар зүйл. Үнэт цаас худалдан авах**

50.1. Дүрэмд өөрөөр заагаагүй бол компани нь төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/-ийн шийдвэрээр өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр худалдан авч болно.

50.2. Компани нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь худалдан авч болох бөгөөд харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджаас 25-н хувиас хэтэрч болохгүй.

50.3. Худалдан авсан хувьцааг халаасны хувьцаа гэж тооцно.

50.4. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн гаргасан үнэт цаасыг худалдан авах шийдвэртээ худалдан авах хувьцаа, ногдол хувийн тоо хэмжээ, үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам зэргийг зааж өгнө.

50.5. Дүрэмд өөрөөр заагаагүй бол компани нь үнэт цаас худалдан авахдаа түүний төлбөрийг бэлэн мөнгөөр, үнэт цаасаар болон бусад эд хөрөнгийн хэлбэрээр хийж болно.

50.6. Компани нь өөрийн үнэт цаасыг анхдагч зах зээлд гаргах үед тэдгээрийг худалдан авч үл болно.

50.7. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэм болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувь нийлүүлэгчдийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол компани нь энгийн хувьцаагаа энэ хуулийн 56 дугаар зүйлд заасан журмын дагуу төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/-өөс тогтоосон зах зээлийн үнээр худалдан авна.

50.8. Компани өөрийн гаргасан энгийн хувьцааны 5-аас дээш хувийг худалдан авах шийдвэрийг дор дурдсанаас бусад тохиолдолд хувь нийлүүлэгчдийн хурлын уг асуудлаар саналын эрхтэй гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэж байна:

50.8.1. хэрэв компани нь энгийн хувьцаагаа худалдан авахдаа хувь нийлүүлэгчдийн эзэмшиж байгаа энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн авахаар шийдвэрлэсэн бол;

50.8.2. энэ хууль болон компанийн дүрэмд заасан хувь нийлүүлэгчдийн давуу эрхийг хэрэгжүүлж байвал;

50.8.3. хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр тогтоосон өөр нөхцөлүүд.

50.9. Өөрийн гаргасан энгийн хувьцааг худалдан авахдаа тэдгээрийг хувь нийлүүлэгчдийн эзэмшиж байгаа энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн авахаар шийдвэрлэсэн бол худалдан авах хувьцааны тоо, худалдан авах үнэ, төлбөр хийх журам, хугацаа, худалдах саналыг хүлээн авах

сүүлчийн өдөр зэргийг багтаасан мэдэгдлийг бүх хувь нийлүүлэгчдэд хүргүүлнэ. Хувьцаат компанийн хувьд энэ саналыг ажлын 30 ба түүнээс дээш хоногийн хугацаатайгаар бүх хувь нийлүүлэгчид хүргүүлнэ. Компанид худалдахаар санал болгож байгаа энгийн хувьцааны нийт тоо нь компанийн худалдан авахаар санал болгосон хувьцааны тооноос илүү байх нөхцөлд компани нь худалдахаар санал болгосон тоонд багтаан илүү хэмжээний хувьцааг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал / -ийн шийдвэрээр худалдан авч болно. Гэхдээ худалдан авах хувьцааны тоо нь энэ хуулийн 50.2-т заасан хэмжээнээс хэтэрч болохгүй бөгөөд энэ тохиолдолд хувьцаагаа хувь нийлүүлэгч бүрийн худалдахаар санал болгож байгаа хувьцааны тоотой хувь тэнцүүлэн худалдаж авна.

**51 дүгээр зүйл. Компани өөрийн давуу эрхийн хувьцааг эргүүлэн авах**

51.1. Төлбөрийн чадвар хангалттай нөхцөлд компани нь эргүүлэн авах үүрэг хүлээсэн давуу эрхийн хувьцааг бүгдийг нь, эсхүл зарим хэсгийг нь хугацаанаас нь өмнө эргүүлэн авахаар санал гаргаж болно. Энэ тохиолдолд энэ хуулийн 66 дугаар зүйлд заасан журмын дагуу тэдгээр үнэт цаасыг эзэмшигчдэд мэдэгдэнэ.

51.2. Эргүүлэн авах үүрэг хүлээсэн үнэт цаасыг анх гаргах үед эргүүлэн авах үнийг тогтоогоогүй бол энэ хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал ***/-өө***с тогтоосон зах зээлийн үнээр худалдан авна.

51.3. Эргүүлэн авах үүрэг хүлээсэн хувьцааг худалдан авах хангалттай хөрөнгөгүй нөхцөлд компани нь шаардагдах хөрөнгөтэй болсноос хойш үнэт цаасыг эргүүлэн авахаар тэдгээрийн эзэмшигч нартай тохиролцон хойшлуулж болно. Тохиролцоогүй тохиолдолд энэ хуулийн 53 дугаар зүйлд заасан этгээдэд худалдан авахыг санал болгоно.

51.4. Өөрийн хувьцааг эргүүлж авснаар өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгөнөөс доогуур болох тохиолдолд компани нь өөрийн энгийн хувьцааг эргүүлэн худалдан авч болохгүй.

**52 дугаар зүйл. Компанийн хувьцааг нэгтгэх болон хуваах**

52.1. Компани нь хоёр буюу түүнээс дээш тооны хувьцааг тухайн төрлийн нэг шинэ хувьцаанд хөрвүүлэх замаар өөрийн хувьцааг нэгтгэж болно.

52.2. Компани нь нэг хувьцааг тухайн төрлийн шинэ хоёр буюу түүнээс дээш тооны хувьцаанд хөрвүүлэх замаар өөрийн гаргасан хувьцааг хувааж болно.

52.3. Хувьцааг хуваах ба нэгтгэсний үр дүнд бий болсон хувьцааны бутархай үлдэгдлийг компани нь энэ хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал***/-өө***с тогтоосон үнээр эргүүлэн авч болно.

52.4. Компанийн хувьцааг нэгтгэх буюу хуваах тухай асуудлыг шийдвэрлэхдээ хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

52.5. Компанийн хувьцааг нэгтгэх буюу хуваахад компанийн зарласан тухайн төрлийн хувьцааны тоонд орсон өөрчлөлтийг компанийн дүрэмд тусгаж бүртгэх байгууллагад мэдэгдэнэ.

52.6. Компанийн хувьцааг нэгтгэх буюу хуваахдаа түүнийг худалдан авах эрхийн бичиг болон түүнд хөрвөх үнэт цаасны бүрдүүлбэрт зохих өөрчлөлт оруулах үүргийг компани хүлээнэ.

**53 дугаар зүйл. Компани өөрийн үнэт цаасыг эргүүлэн авах нөхцөл**

53.1. Компани нь дор дурдсан нөхцөлд өөрийн гаргасан үнэт цаасыг худалдан авах болон эргүүлэн авч болно:

53.1.1. компани нь үнэт цаасаа худалдан авах болон эргүүлэн авмагц шууд төлбөрийн чадвартай байх;

53.1.2. компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан доод хэмжээ болон давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх.

***53.2. Энэ хуулийн 54 дүгээр зүйлд заасан эргүүлэн авах үүрэг бүхий энгийн хувьцааг эргүүлэн авсаны дараа компани нь бусад энгийн хувьцаа болон түүнд хамаарах үнэт цаасыг худалдан авч болно.***

53.3. Хувьцаа худалдан болон эргүүлэн авсаны үр дүнд компанийн өөрийн хөрөнгө нь 25-аас дээш хувиар багассан тохиолдолд компани нь төлбөр хийсэн өдрөөс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчдэд өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ.

**54 дүгээр зүйл. Хувь нийлүүлэгчдийн шаардлагаар компани хувьцаагаа эргүүлэн авах**

54.1. Дор дурдсан асуудлаар хувь нийлүүлэгчдийн хурлаас гаргасан шийдвэрийн эсрэг саналтай байсан буюу санал хураалтад оролцоогүй хувь нийлүүлэгч бүр өөрийн эзэмшиж байгаа хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах эрхтэй:

54.1.1. нийлэх, нэгдэх, хуваах болон хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах;

54.1.2. компани энэ хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасны дагуу хувь нийлүүлэгчдийн хурлаар батлах шаардлагатай их хэмжээний хэлцэл хийсэн;

54.1.3. компанийн хувь нийлүүлэгчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан;

54.1.4. компанийн дүрэмд заасан бусад тохиолдол.

54.2. Хувь нийлүүлэгч нь түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-ээс дээш хувийг эзэмшиж байгаа, түүнчлэн төрийн өмчийн эзэмшилд байсан компанийн хяналтын багц хувьцааг хувьчлан авсан тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигч бүр компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.

Компани нь хяналтын багц хувьцааг эзэмшиж байгаа этгээдэд энэ хуулийн 54. 4.-т заасан үнээр худалдан авахыг зөвшөөрч болно.

54.3. Өөрийн эзэмшилд байгаа хувьцааг компанид эргүүлж авахыг шаардах эрхтэй хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалтыг эргүүлэн авахыг шаардах эрх үүссэн өдөр компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлд байсан мэдээллийг үндэслэн гаргана.

54.4. Компани нь хувь нийлүүлэгчдийн шаардлагаар эргүүлэн авах хувьцааг энэ эрхийг үүсгэсэн шийдвэрийн улмаас хувьцааны үнэд орсон өөрчлөлтийг үл харгалзан энэ хуулийн 56 дугаар зүйлд заасан журмын дагуу төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/-өөс тодорхойлсон зах зээлийн үнээр худалдан авна.

**55 дугаар зүйл. Хувьцааг эргүүлэн авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журам**

55.1. Энэ хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу хувь нийлүүлэгч нь хувьцаагаа эргүүлэн авахыг компаниас шаардах эрх үүсгэсэн шийдвэр гарах тохиолдол бүрт компани нь энэ эрх, түүнийг хэрэгжүүлэх журмын талаар хувь нийлүүлэгчдэд мэдэгдэх үүрэгтэй.

55.2. Өөрийн эзэмшиж байгаа хувьцааг компани эргүүлж авахыг шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувь нийлүүлэгч нь эргүүлж авах тухай шаардлагыг бичгээр гаргах бөгөөд түүнд өөрийн овог, нэр, оршин суугаа хаяг болон эргүүлэн авахыг шаардаж байгаа хувьцааны тоо, төрлийг заана.

55.3. Хувь нийлүүлэгч нь хувьцааг компанид эргүүлэн авах тухай өөрийн шаардлагыг уг эрхийг үүсгэсэн шийдвэр гарснаас, эсхүл ийм эрх үүссэн тухай компаниас бичгээр мэдэгдэл авсанаас хойш ажлын 30 хоногийн дотор компанид явуулна.

55.4. Хувь нийлүүлэгч нь түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75 ба түүнээс дээш хувийг худалдан авах болон хувьчлалын дүнд хяналтын багцыг худалдан авсан тохиолдолд бусад хувь нийлүүлэгчид эзэмшиж байгаа хувьцаагаа эргүүлэн авахыг шаардаж болох талаар төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-өөс дээр дурдсан хувьцааг худалдан авсан өдрөөс хойш ажлын 30 хоногийн дотор хувь нийлүүлэгчид

мэдэгдэх үүрэгтэй. Хувь нийлүүлэгчид энэ мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 30 хоногийн дотор шаардлагаа бичгээр явуулна.

55.5. Компани нь хувьцааг эргүүлэн авах тухай хувь нийлүүлэгчдийн шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 30 хоногийн дотор эргүүлэн авах эрхийн тухай мэдээлсэн мэдэгдэлд дурдсан зах зээлийн үнээр худалдан авах, эсхүл тэдгээрийн эргүүлэн авах эрхийг хэрэгжүүлэхээс татгалзсан үндэслэлээ хувь нийлүүлэгчдэд мэдэгдэнэ.

55.6. Компани хувьцаагаа энэ зүйлд заасны дагуу эргүүлэн авахаас татгалзсан, эсхүл эргүүлэн авахаар тодорхойлсон зах зээлийн үнэ бодитой бус гэж үзвэл хувь нийлүүлэгч нь энэ талаархи гомдлоо уг шийдвэр гарснаас хойш 3 сарын дотор шүүхэд гаргаж болно.

55.7.Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь эргүүлэн авах хувьцааны зах зээлийн үнийн талаархи нэмэлт мэдээллээр хувь нийлүүлэгчдийг хангана.

**56 дугаар зүйл. Эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тодорхойлох**

56.1. Компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн/компанийн хувьцаа болон бусад үнэт цаасыг оролцуулан/ зах зээлийн үнэ гэж эдгээр эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн үнийн талаар бүрэн мэдээлэлтэй, түүнийг худалдах үүрэг хүлээгээгүй худалдагч болон эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн үнийн талаар бүрэн мэдээлэлтэй, худалдан авах үүрэг хүлээгээгүй худалдан авагч хоёрын харилцан тохиролцсон үнийг хэлнэ.

56.2. Энэ хууль болон компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/ тогтооно.

56.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн аль нэг гишүүн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн үнийг тогтоох шаардлагатай хэлцлийг компанитай байгуулахыг сонирхож байгаа тохиолдолд зах зээлийн үнийг уг хэлцлийг байгуулах талаар сонирхолгүй төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн олонхийн саналаар тогтооно.

Энэ тохиолдолд уг хэлцэлд оролцогч, зуучлагч талуудтай нэгдмэл сонирхолгүй, энэ хэлцлээс шууд болон шууд бус замаар санхүүгийн ямар нэг ашиг аваагүй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг хараат бус гэж үзнэ.Хэрэв энэ шийдвэрийг хувь нийлүүлэгчдийн хурлаас гаргах бол уг асуудлаар сонирхлын зөрчилтэй хувь нийлүүлэгч санал хураалтад оролцох эрхгүй.

56.4. Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/ энэ хуулийн 56.2.-т заасны дагуу эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоохдоо хараат бус үнэлгээний байгууллага, аудиторийн дүгнэлтийг ашиглаж болно.

Харин хувьцаат компанийн хувьд энэ хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу хувьцааг эргүүлэн авах тохиолдолд хувьцааны үнийг хараат бус үнэлгээний байгууллага, аудиторийн дүгнэлтийг үндэслэн тодорхойлно.

Нийтэд худалдагдаж байгаа хувьцаа болон бусад үнэт цаасны зах зээлийн үнийг тогтоохдоо Хөрөнгийн биржийн албан ёсны мэдээнд тусгагдсан арилжааны сүүлийн 6 сарын дундаж ханшийг харгалзан тогтооно.

Компанийн хувьцаа болон бусад үнэт цаасны зах зээлийн үнийг тогтоохдоо хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, компанийн өөрийн хөрөнгө, ашиг зэргийн талаар бүрэн мэдээлэлтэй худалдан авагчаас өгөх боломжит үнэ болон бусад хүчин зүйлийг харгалзан үзнэ.

## НАЙМДУГААР БҮЛЭГ

### Хувьцааны хяналтын багцыг худалдан авах

**57 дугаар зүйл. Хувьцааны хяналтын багц, түүнийг худалдан авах**

57.1. Компанийн гаргасан энгийн хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг компанийн хяналтын багц гэнэ.

57.2. Хувьцаат компанийн энгийн хувьцааны хяналтын багцыг дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авах хүсэлтэй этгээд нь энэ хууль болон Үнэт цаасны тухай хуульд заасан журмын дагуу энэ тухайгаа нийтэд мэдээлэх замаар худалдан авах санал гаргана.

57.3. Хяналтын багцыг худалдан авахаар санал болгосон хувьцаат компанийн хувь нийлүүлэгчдийн хурал нь энэ асуудлаар саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн саналын олонхоор тусгайлан шийдвэр гаргаагүй бол хяналтын багцыг эзэмшихээр санал гаргасан этгээдэд хувь нийлүүлэгчдийн зүгээс хувьцаагаа худалдахад нь ямар нэг саад учруулах эрхгүй.

**58 дугаар зүйл. Компанийн хувьцааг худалдан авахыг хувь нийлүүлэгчдэд санал болгох**

58.1. Компанийн хувьцааны хяналтын багцыг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан этгээд нь уг хяналтын багцыг худалдан авсан өдрөөсөө хойш ажлын 60 хоногийн дотор багтаан бусад хувь нийлүүлэгчдийн эзэмшиж байгаа хувьцааг уг хувьцааны сүүлийн 6 сарын зах зээлийн үнийн жигнэсэн дунджаас доошгүй үнээр худалдан авахаар санал болгох үүрэгтэй.

58.2. Компанийн хувьцааны хяналтын багцыг худалдан авсан этгээд нь энэ хуулийн 58.1.-д заасан саналыг гаргаагүй бол уг этгээд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн эзэмшиж байгаа хувьцаа нь саналын эрх эдлэхгүй.

Бусад хувь нийлүүлэгчдийн хувьцааг худалдан авах саналыг хувь нийлүүлэгчдийн хурлын зар мэдээг хүргэдэг аргаар хувь нийлүүлэгчдэд мэдэгдэнэ. Хувьцаат компанийн хувьд Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид энэ мэдэгдлийг нэгэн адил хүргүүлнэ.
*/Энэ хэсэгт 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

Энэ саналд хяналтын багц хувьцааг худалдан авсан этгээд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн овог, нэр, хаяг, тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны тоо, худалдан авах үнийн санал болон саналыг хаах эцсийн хугацаа зэргийг тусгасан байна.

58.3. Компанийн хувьцааны хяналтын багцыг худалдан авсан этгээд нь энэ хуулийн 58.1.-д заасан саналыг гаргахдаа уг саналыг хаах хугацаа нь хувь нийлүүлэгчдэд саналаа явуулснаас хойш 30 ба түүнээс дээш хоног байхаар тогтооно.

58.4. Хэрэв хувьчлалын дүнд хяналтын багцыг авсан бол энэ хуулийн 58.1.-д заасан заалт үйлчлэхгүй бөгөөд компани хувьцаагаа эргүүлэн авах асуудал нь энэ хуулийн 54, 55 дугаар зүйлд заасны дагуу зохицуулагдана.

**59 дүгээр зүйл. Компанийн хувьцааны хяналтын багцыг худалдан авсан тухай мэдэгдэх**

59.1. Хувьцаат компанийн энгийн хувьцааны гуравны нэгээс дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт худалдан авсан буюу эзэмшиж байгаа этгээд нь энэ хэмжээний хувьцааг худалдан авсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор өөрийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн овог, нэр, хаяг, тус бүрийн эзэмшилд байгаа хувьцааны тоо зэргийн талаархи мэдэгдлийг тухайн компани болон Санхүүгийн зохицуулах хороонд тус тус бичгээр хүргүүлнэ.

*/Энэ хэсэгт 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

## ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

## Компанийн удирдлага

**60 дугаар зүйл. Хувь нийлүүлэгчдийн хурал**

60.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувь нийлүүлэгчдийн хурал байна. Нэг хувь нийлүүлэгчтэй компанийн хувьд хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхийг хувь нийлүүлэгч өөрөө хэрэгжүүлнэ.

60.2. Хувь нийлүүлэгчдийн хурал ээлжит болон ээлжит бус байна.

60.3. Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлыг компанийн санхүүгийн жил дуусcанаас хойш 4 сарын дотор зарлан хуралдуулна. Энэ хугацаанд ээлжит хурлыг зарлаагүй тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/- ийн бүрэн эрх дуусгавар болж хувь нийлүүлэгчдийн хурал зарлах бүрэн эрх хяналтын зөвлөлд шилжинэ. Хяналтын зөвлөл хувь нийлүүлэгчдийн хурлыг бүрэн эрх шилжсэнээс хойш ажлын 15 хоногийн дотор зарлах үүрэгтэй. Хяналтын зөвлөл энэ үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд уг компанийн аливаа нэг хувь нийлүүлэгч хувь нийлүүлэгчдийн хурлыг зарлахыг шаардаж шүүхэд хандах, эсхүл өөрөө зарлан хуралдуулж болно. Энэ тохиолдолд хувь нийлүүлэгчдийн хурлыг зарлах, хуралдуулах зардлыг компани гаргана.

60.4. Компанийн хувь нийлүүлэгчдийн хурлыг тухайн хурлаас сонгогдсон дарга удирдана.Хэрэв хурал өөр хүн сонгоогүй бол хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь хувь нийлүүлэгчдийн хурлыг удирдана.

60.5. Шаардлагатай гэж үзвэл төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага, эсхүл саналын эрхийн 10 ба түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгчдийн санаачилгаар ээлжит бус хурлыг энэ хуулийн 62 дугаар зүйлд заасан журмын дагуу зарлан хуралдуулж болно.

**61 дүгээр зүйл. Хувь нийлүүлэгчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах**

61.1. Хувь нийлүүлэгчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/, эсхүл энэ хуулийн 60.3., 62.7.-д заасан этгээд гаргана.

61.2. Хурал хуралдуулах тухай шийдвэрт дараахь зүйлийг заана:

61.2.1. хурал хуралдуулах газар, өдөр болон цаг;

61.2.2. хурлын хэлэлцэх асуудал ;

61.2.3. хувьцаат компанийн хувьд хуралд оролцох эрхтэй хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;

61.2.4. хурал хуралдуулах тухай хувь нийлүүлэгчид мэдэгдэх өдөр, журам;

61.2.5. хуралд бэлтгэх явцад хувь нийлүүлэгчдийн танилцаж болох бичиг, баримтын жагсаалт;

61.2.6. санал авах хуудсаар санал авах тохиолдолд санал авах хуудсын агуулга;

61.2.7. санал авах хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр.

**62 дугаар зүйл. Ээлжит бус хурал**

62.1. Шаардлагатай гэж үзвэл төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.

62.2. Саналын эрхийн 10 ба түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгчид нь, хянан шалгах зөвлөл, төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-д ээлжит бус хурал хуралдуулах тухай шаардлага гаргах эрхтэй. Шаардлагыг бичгээр гаргана.

62.3. Шаардлагад уг хувь нийлүүлэгчийн овог, нэр, ээлжит бус хурал хуралдуулах болсон шалтгаан, хэлэлцэн шийдвэрлэх асуудал, шаардлага гаргасан этгээдийн эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоог заана.

62.4. Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь ээлжит бус хурлыг хуралдуулах тухай шаардлага хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор хурал хуралдуулах эсэх талаар шийдвэр гаргана.

62.5. Гагцхүү дараахь тохиолдолд ээлжит бус хурлыг хуралдуулахаас татгалзах шийдвэр гаргах бөгөөд энэ шийдвэр, татгалзсан үндэслэлийн талаар шаардлага гаргасан хувь нийлүүлэгчид даруй мэдэгдэнэ :

62.5.1. ээлжит бус хурал хуралдуулах тухай шаардлага гаргасан хувь нийлүүлэгчийн саналын эрх нь нийт саналын эрхийн 10 хувьд хүрээгүй;

62.5.2. ээлжит бус хурлаар хэлэлцэхээр санал болгож байгаа асуудал нь хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхэд хамаарахгүй.

62.6. Энэ шийдвэрийн талаархи гомдлыг шүүхэд гаргаж болно.

62.7. Энэ хуулийн 62.4. -т заасан хугацаанд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ шийдвэр гаргаагүй тохиолдолд шаардлага тавьсан этгээд ээлжит бус хурал хуралдуулах тухай бие даан шийдвэр гаргаж болно.Энэ тохиолдолд хувь нийлүүлэгчдийн хурал зөвшөөрвөл хурлыг зарлах, хуралдуулахтай холбогдсон зардлыг компани хариуцаж болно.

62.8. Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/нь хурал хуралдуулах тухай шийдвэр гаргасан тохиолдолд шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 45 хоногийн дотор хурлыг хуралдуулна.Энэ тохиолдолд хурал хуралдуулахтай холбогдсон зардлыг компани хариуцна.

**63 дугаар зүйл. Хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрх**

63.1.Дор дурдсан асуудлыг зөвхөн хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ:

63.1.1. компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах;

63.1.2. нийлэх, нэгдэх, хуваах буюу өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах;

63.1.3. компанийн өрийг хувьцаагаар солих;

63.1.4. компанийн хэлбэрийг өөрчлөх;

63.1.5. компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

63.1.6. хувьцааг хуваах буюу нэгтгэх;

63.1.7. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

63.1.8. хянан шалгах зөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

63.1.9. энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хувь нийлүүлэгчид нь хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлэх эсэх;

63.1.10. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

63.1.11. энэ хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах;

63.1.12. энэ хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;

63.1.13. энэ хуульд заасны дагуу компани өөрийн хувьцаагаа худалдан авахыг зөвшөөрөх ;

63.1.14. хэрэв компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

63.1.15. төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлууд;

63.1.16. энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудлууд .

63.2. Төлөөлөн удирдах зөвлөлгүй хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувь нийлүүлэгчдийн хурал нь энэ хуулийн 63.1 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

63.2.1. компанийн үнэт цаасыг гаргах;

63.2.2. гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг тогтооох;

63.2.3. компанийн гүйцэтгэх захирал болон хамтын гүйцэтгэх удирдлагын гишүүдийг сонгох, тэдгээрийн бүрэн эрхийг тогтоох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох;

63.2.4. гүйцэтгэх удирдлагын гишүүний цалин урамшууллыг тогтоох ;

63.2.5. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гүйцэтгэх удирдлагаас гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах ;

63.2.6. компанийн аудиторыг сонгож, гэрээ байгуулах;

63.2.7. ногдол ашгийн хэмжээг тогтоож, төлөх журмыг батлах;

63.2.8. гүйцэтгэх удирдлагын дотоод зохион байгуулалтыг батлах;

63.2.9. компанийн салбар болон төлөөлөгчийн газрыг байгуулах;

63.2.10. энэ хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу компанийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тодорхойлох;

63.2.11. энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудлууд;

63.2.12. гүйцэтгэх удирдлага болон хувь нийлүүлэгчдийн саналаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлууд.

**64 дүгээр зүйл. Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох**

64.1. Хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэж байгаа асуудлыг санал хураалтаар шийдвэрлэхэд энгийн хувьцаа эзэмшигчид энэ хуулийн 35 дугаар зүйл, давуу эрхийн хувьцаа эзэмшигчид энэ хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу саналын эрх эдэлнэ.

64.2. Хуульд өөрөөр заагаагүй бол нэг хувьцаа саналын нэг эрхтэй байна.

64.3. Саналын эрхтэй хувь нийлүүлэгч нь санал хураалтаар шийдвэрлэх асуудал бүрээр санал өгөх эрхтэй. Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр саналын эрхтэй байх хувьцааны төрлийг тодорхойлно.

64.4. Энэ хууль болон компанийн дүрэмд энэ зүйлд зааснаас дээгүүр хэмжээ тогтоогоогүй бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх зөвлөл**/**-ийн гишүүдийг сонгохоос бусад асуудлыг хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувь нийлүүлэгчдийн саналын олонхоор шийдвэрлэнэ. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн гишүүдийг сонгохдоо нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан хүнийг сонгоно**.**

64.5. Энэ хуулийн 63.1.1-63.1.6, 63.1.12-д заасан асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ. Компанийн дүрмээр эдгээр асуудлыг шийдвэрлэх саналын тоог энэ хэсэгт зааснаас дээгүүр тогтоож болно.

64.6. Хэлэлцэх асуудлын онцлогоос шалтгаалан зарим асуудлын хэлэлцэх журмыг компанийн дүрэмд тусгайлан тогтоож болно.

64.7. Хувь нийлүүлэгчдийн хурал нь хэлэлцэх асуудалд ороогүй асуудлыг хэлэлцэж болохгүй. Шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 67 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд хэлэлцэх асуудлыг нэмж оруулах журмыг компанийн дүрэмд зааж болно.

**65 дугаар зүйл. Хуралд оролцох эрх**

65.1. Хуралд оролцох эрхтэй хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалтыг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага***/-өө***с тогтоосон бүртгэлийн өдрөөр тасалбар болгон компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх эрх бүхий этгээд гарган хурал зарласан этгээдэд хүргүүлнэ.

Хувьцаат компанийн хувьд бүртгэлийн өдрийг төлөөлөн удирдах зөвлөл хувь нийлүүлэгчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргах үед тогтоох бөгөөд энэ өдөр нь хурал хуралдах өдрөөс 45 хоногоос өмнө байж болохгүй. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьд хувь нийлүүлэгчдийн хурал болох өдөр нь бүртгэлийн өдөр болно.

65.2. Хуралд оролцох эрхтэй хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалт нь хувь нийлүүлэгч бүрийн овог нэр, хаяг, түүний эзэмшилд байгаа хувьцааны төрөл, тооны талаархи мэдээг агуулсан байна.

65.3. Компани нь хуралд оролцох эрхтэй хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалтыг компанийн энгийн хувьцааны 10 ба түүнээс дээш хувийг эзэмшигч этгээдэд шаардсан тохиолдолд түүнд танилцуулах үүрэгтэй.

65.4. Төлөөлөн удирдах зөвлөл хувь нийлүүлэгчдийн бүртгэлийг эрхлэх эрх бүхий этгээдийн бичгээр ирүүлсэн зөвшөөрлийг үндэслэн хуралд оролцох эрхтэй хувь нийлүүлэгчдийн бүртгэлд өөрчлөлт оруулна.

**66 дугаар зүйл. Хурлын зар мэдээг хүргэх**

66.1. Хурал зарлагч этгээд нь хурлын тухай зар мэдээг хуралд оролцох эрхтэй хувь нийлүүлэгчдэд мэдээлэх үүрэг хүлээнэ.

66.2. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хурлын зар мэдээг хүргэх журам, хугацааг компанийн дүрмээр тогтоож болно.

Хувьцаат компанийн хурлын зар мэдээг хүргэх журмыг Санхүүгийн зохицуулах хороо тогтоож болно.
*/Энэ хэсэгт 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

66.3. Хурлын тухай зар мэдээнд компанийн оноосон нэр, байршил, хурал хийх өдөр, цаг, газар, бүртгэлийн өдөр, хурлаар хэлэлцэх асуудал болон гаргах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох бичиг баримттай танилцах журам зэрэг энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад мэдээллийг тусгасан байна.

Санал авах хуудсаар саналыг урьдчилан авах тохиолдолд санал авах хуудсыг хүлээн авах газар, сүүлчийн хугацааг тусгайлан мэдээлнэ.

66.4. Хувь нийлүүлэгчдэд дараахь бичиг баримтыг танилцуулна:

66.4.1. компанийн санхүүгийн жилийн тайлан;
66.4.2. санхүүгийн жилийн тайлангийн талаархи аудиторын дүгнэлт;
***66.4.3. санхүүгийн өмнөх жилд хийгдсэн сонирхлын зөрчил бүхий хэлцлүүд, тэдгээр нь энэ хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан журмын дагуу хийгдсэн тухай аудиторын дүгнэлт;***

66.4.4. компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн гишүүдэд нэр дэвшсэн хүний тухай танилцуулга;

66.4.5. компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүд, тэдгээрийн эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо;

66.4.6. компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын зардал, цалин урамшуулал;

66.4.7. хувьцаат компанийн хувьд бизнесийн үйл ажиллагааны тайлан;
66.4.8. хувь нийлүүлэгчдийн хурлын хэлэлцэх асуудалтай холбогдсон хувь нийлүүлэгчдийн зайлшгүй мэдэх ёстой бусад мэдээлэл.

66.5. Компани нь хурал хийх тухай мэдэгдэл гаргасан өдрөөс эхлэн хувь нийлүүлэгчид дээрх бичиг баримттай танилцах боломжийг хангах үүрэг хүлээнэ.

**67 дугаар зүйл. Хурлын хэлэлцэх асуудалд санал оруулах**

67.1. Саналын эрх бүхий энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгч нь ээлжит хурал хуралдахаас ажлын 45 ба түүнээс дээш хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.

67.2. Нэмэлт саналаа бичгээр гаргах бөгөөд түүнд гаргаж байгаа санал, түүний шалтгаан, санал оруулж байгаа хувь нийлүүлэгчийн овог, нэр, түүний эзэмшилд байгаа хувьцааны төрөл, тоог тусгана. Хэрэв төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшүүлж байвал нэр дэвшигчийн овог, нэр /хэрэв компанийн хувь нийлүүлэгч бол эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо/, дэвшүүлж байгаа хувь нийлүүлэгчийн овог, нэр, эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоог тусгасан мэдэгдлийг бичгээр гаргана. Уг мэдэгдэлд нэр дэвшүүлж байгаа шалтгаанаа зааж болно.

67.3. Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага / нь гаргасан нэмэлт саналыг дор дурдсанаас бусад тохиолдолд хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтанд уг саналыг хүлээн авсанаас хойш ажлын 15 хоногийн дотор багтаан оруулах үүрэг хүлээнэ:

67.3.1. санал гаргагч нь энэ хуулийн 67.1.-д заасан болзолыг хангаагүй;
67.3.2. энэ хуулийн 67.2.-т заасан мэдээллийг бүрэн тусгаагүй.

67.4. Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь нэмэлт саналыг ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг шийдвэр гарсанаас хойш ажлын 3 хоногийн дотор санал гаргасан хувь нийлүүлэгчид хүргүүлнэ. Энэ шийдвэрийн талаар санал гаргагч шүүхэд гомдол гаргаж болно.

67.5. Хувь нийлүүлэгчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш хурлын товд өөрчлөлт оруулахыг хориглоно.

**68 дугаар зүйл. Хурлын тооллогын комисс**

68.1. Хувьцаат компанийн хувьд тооллогын комиссыг компанийн төлөөлөн удирдах зөвлөл томилон ажлуулна. Тооллогын комиссын үүргийг хөндлөнгийн гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхээр хувь нийлүүлэгчдийн хурлаас тогтоож болно.

68.2. Хэлэлцэх асуудалтай шууд холбоотой компанийн албан тушаалтан болон эдгээр хүмүүстэй нэгдмэл сонирхолтой этгээдийг хурлын тооллогын комиссын гишүүнээр томилохыг хориглоно.

68.3. Хурлын тооллогын комисс дараахь үүрэг хүлээнэ:

68.3.1. хурлын ирц /кворум/-ыг тогтоож хурлын даргад мэдээлэх;
68.3.2. тухайн хурлын хэлэлцэх асуудал бүрээр оролцогч этгээд бүрийн саналын эрхийн хэмжээг тогтоох;

68.3.3. хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах асуудалд тайлбар өгөх;

68.3.4. санал өгөх журмыг тайлбарлах;
68.3.5. санал өгөх журам болон хувь нийлүүлэгчдийн санал өгөх эрхийг хангах;
68.3.6. санал хураалтыг санал авах хуудсаар явуулж байгаа тохиолдолд санал авах хуудсыг тоолж, хүлээн авах;

68.3.7. санал хураалтын дүнг тоолж энэ тухай тэмдэглэл хөтлөх;
68.3.8. санал тоолж санал хураалтын дүнг нэгтгэж дүнгийн тухай шийдвэр гарган тооллогын комиссын дарга гарын үсэг зурж /тооллогын комиссын дарга нь тооллогын үр дүнгийн үнэн зөвийг хариуцна/ хуралд танилцуулах;

68.3.9. санал авах хуудсыг компанийн архивт хадгалуулахаар шилжүүлэх.

68.4. Төлөөлөн удирдах зөвлөлөөс хурлын тооллогын комисст хурал хийхтэй холбогдсон бусад үүргийг хариуцуулж болно.

**69 дүгээр зүйл. Хуралд оролцох журам**

69.1. Хувь нийлүүлэгч нь хуралд өөрийн биеэр буюу Иргэний хуульд заасны дагуу бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн оролцож болно.

69.2. Төлөөлж оролцох этгээд энэ тухайгаа төлөөлөн удирдах зөвлөлд хурал эхлэхээс өмнө мэдэгдэнэ. Төлөөлөх тухай итгэмжлэл нь гагцхүү тухайн хуралд хүчинтэй. Хурал хойшилсон

боловч тухайн хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл дараагийн хуралд хүчинтэй байна.

69.3. Санал авах хуудсаар саналаа ирүүлсэн хувь нийлүүлэгчийг хуралд оролцсонд тооцно.

69.4. Хувьцаат компанийн хувьд бүртгэлийн өдрөөс хойш хувьцаагаа бусдад шилжүүлсэн этгээд, шинэ эзэмшигч этгээдэд хуралд оролцох итгэмжлэл олгох, эсхүл уг шинэ эзэмшигч этгээдийн өгсөн зааврын дагуу санал өгч болно.

69.5. Компанийн хувьцааг хэд хэдэн этгээд дундаа хэсгээр өмчилж байгаа тохиолдолд хуралд оролцож санал өгөх эрхийг дундаа хэсгээр өмчлөгчдийн харилцан тохиролцсоноор тэднийг хэн нэг нь, эсхүл тэдний хамтын төлөөлөгч хэрэгжүүлнэ. Эдгээр этгээдийн төлөөлөн оролцох эрхийг Иргэний хуульд заасны дагуу баталгаажуулсан байна.

**70 дугаар зүйл. Хурлын ирц /кворум/, хурал хүчин төгөлдөр болох**

70.1. Компанийн саналын эрхтэй хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгчид хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.Компанийн дүрмээр ирцийн хувийг энэ зүйлд зааснаас дээгүүр тогтоож болно.

70.2. Энэ хуулийн 70.1.-д заасан хувь хүрээгүй бол хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэж дахин хуралдах өдрийг товлоно.Харин хойшлогдсон хурлаар хэлэлцэх асуудлыг өөрчилж үл болно.

70.3. Компанийн дүрмээр илүү өндөр хувь тогтоогоогүй бол саналын эрхийн 20 ба түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгчид хуралд оролцсоноор хойшлогдсон хурал хүчин төгөлдөр болно.

70.4. Компанийн дүрмээр илүү өндөр хувь тогтоогоогүй бол энэ хуулийн 63.1.1-63.1.6-д заасан асуудлыг хэлэлцэх хойшлогдсон хурал нь саналын эрхийн гуравны нэгээс доошгүй хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгчид оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

70.5. Хойшлогдсон хурлыг ажлын 20 хоногийн дотор хуралдуулна. Уг хурал хуралдахаас ажлын 7 ба түүнээс дээш хоногийн өмнө хойшлогдсон хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ.

70.6. Хувьцаат компанийн хувьд хойшлогдсон хуралд бүртгэлийн өдрийг өөрчлөхгүй.

70.7. Түрүүчийн хуралд ирүүлсэн саналыг хойшлогдсон хурлын ирц, санал хураалтын дүнд тооцно.

70.8.Хойшлогдсон хурал нь ажлын 20 хоногийн дотор хуралдаж чадахгүй бол шинээр хурал зарлах бөгөөд ирц /кворум/ -ийг энэ хуулийн 70.1.-д зааснаар тогтооно.

**71 дүгээр зүйл. Санал авах хуудас**

71.1. Хувьцаат компанийн хувь нийлүүлэгчдийн хурлын саналыг санал авах хуудсаар авах бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай компани нь энэ аргыг хэрэглэж болно.

71.2. Хувь нийлүүлэгчид хурлын шийвэрт өгөх саналаа санал авах хуудсанд тэмдэглэн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн тогтоосон журмын дагуу тооллогын комисст ирүүлнэ.

71.3. Санал авах хуудсын агуулга, загварыг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирлага/ батална. Санал авах хуудсанд дараахь зүйлийг тусгана:

71.3.1. компанийн оноосон нэр;
71.3.2. хурал хийх газар, өдөр, цаг;
71.3.3. хувь нийлүүлэгчийн нэр, эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо;
71.3.4. санал хураалтаар шийдвэрлэх асуудлын томъёолол, сонгуульд оролцох нэр дэвшигчийн овог нэр;

71.3.5. төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийг сонгоход хэрэглэх санал хураах аргын нэр /ердийн, кумулятив/;

71.3.6 .асуудал бүрээр ердийн журмаар саналаа өгөхөд "зөвшөөрсөн", "татгалзсан", "түдгэлзсэн" алин болохыг тэмдэглэсэн саналын хуудсыг, сонгуульд кумулятив аргаар санал өгөхөд уг аргын тухай тайлбар бүхий тухайн нэр дэвшигчид өгөх саналын тоог тус тус тэмдэглэсэн саналын хуудсыг хэрэглэнэ.

**72 дугаар зүйл. Санал авах хуудсыг хүчинтэйд тооцох**

72.1. Санал авах хуудсаар өгсөн саналыг дараахь тохиолдолд хүчинтэйд тооцно:

72.1.1. ердийн журмаар санал өгөх асуудалд санал өгөх хувилбарын зөвхөн нэгийг тэмдэглэсэн;

72.1.2. төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийг ердийн журмаар санал хурааж сонгох тохиолдолд нэр дэвшигчийн төлөө өгсөн зөвшөөрсөн санал нь сонгогдох гишүүдийн тооноос илүүгүй байх;

72.1.3. нэр дэвшигчийн төлөө өгөх саналаа кумулятив аргаар санал хурааж сонгох тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшигч бүрд өгсөн саналын тооны нийлбэр нь тухайн хувь нийлүүлэгчийн саналын эрхийн тооны нийт дүнгээс илүүгүй байх бөгөөд саналын эрхийн тооны нийт дүн нь тухайн хувь нийлүүлэгчийн эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна.

72.2. Төлөөлөн удирдах зөвлөл болон бусад удирдлагын байгууллагын гишүүнийг сонгохоос бусад тохиолдолд санал өгөх хувилбарын зөвхөн нэгийг нь тэмдэглэсэн байна.

**73 дугаар зүйл. Эчнээ санал хураалтаар компанийн хувь нийлүүлэгчид шийдвэр гаргах**

73.1. Хувьцаат компани нь хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдуулахгүйгээр хувь нийлүүлэгчдээс эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэрлэж болно. Эчнээ санал хураалтыг санал авах хуудсыг ашиглан явуулна.

Ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулж үл болно.

73.2. Эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл гаргана. Эчнээ санал хураалт явуулах тухай шийдвэрт дараахь зүйлийг тусгана:

73.2.1. эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлууд;

73.2.2. саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийг тодорхойлох бүртгэлийн өдөр;

73.2.3. санал авах хуудсыг хувь нийлүүлэгчдэд хүргүүлэх хугацаа;

73.2.4. санал авах хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр;

73.2.5. санал авах хуудсын агуулга болон загвар;

73.2.6. эчнээ санал хураалт явуулахтай холбогдуулан хувь нийлүүлэгчид танилцуулах, бичиг баримтын жагсаалт эдгээртэй танилцах боломж, газар.

73.3. Эчнээ санал хураалтад оролцох эрхтэй хувь нийлүүлэгчдийг энэ хуулийн 65, 69 дүгээр зүйлд заасны дагуу тодорхойлно.

73.4. Санал авах хуудсанд энэ хуулийн 71.3. 1, 71.3. 3, 71.3. 4, 71.3. 5, 71.3. 6-д заасан мэдээллийг тусгахын зэрэгцээ санал авах хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг заасан байна.

73.5. Хувьцаат компанийн хувьд эчнээ санал хураалтын санал авах хуудсыг түүнийг эргүүлж хүлээн авах сүүлчийн өдрөөс ажлын 30 ба түүнээс дээш хоногийн өмнө хувь нийлүүлэгчдэд тараана.

73.6. Нийт саналын эрхийн 50-иас дээш хувийг эзэмшигчид саналаа ирүүлснээр эчнээ санал хураалтыг хүчинтэйд тооцно. Саналаа ирүүлсэн хувь нийлүүлэгчдийн саналын олонхоор тухайн асуудлыг шийдвэрлэнэ.

73.7. Эчнээ санал хураалтаар ирүүлсэн саналыг тоолох, дүнг гаргах ажлыг энэ хуулийн 68 дугаар зүйлд заасан эрх, үүрэг бүхий тооллогын комисс зохион байгуулна.

73.8. Тооллогын комисс нь санал авах хуудсыг хүлээн авсан сүүлчийн өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор эчнээ санал хураалтын дүнгийн тухай тайлан гаргаж тооллогын комиссын дарга гишүүд гарын үсэг зурж төлөөлөн удирдах зөвлөлд хүлээлгэн өгнө.

73.9. Эчнээ санал хураалтын дүнгийн тухай тайланд дараахь зүйлийг тусгана:

73.9.1. санал авах хуудсыг хувь нийлүүлэгчдэд тараасан өдөр;

73.9.2. эчнээ санал хураалтаар шийвэрлэх асуудлууд;

73.9.3. санал ирүүлсэн хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалт, эзэмшиж байгаа хувьцааны тоо;

73.9.4. шийдвэрлэх асуудал бүрээр саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн өгсөн саналын нийт тоо;

73.9.5. эчнээ санал хураалтын дүн;

73.9.6. эчнээ санал хураалтаар гаргасан шийдвэр.

73.10. Тооллогын комиссын тайланг үндэслэн гаргасан шийдвэрийг тайлан хүлээн авснаас хойш ажлын 7 хоногийн дотор төлөөлөн удирдах зөвлөл хувь нийлүүлэгчид мэдээлнэ.

**74 дүгээр зүйл. Хувь нийлүүлэгчдийн хурлын тэмдэглэл**

74.1. Хувь нийлүүлэгчдийн хурал дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор хурлын тэмдэглэлийг гаргах бөгөөд хурлын дарга гарын үсгээ зурна. Хурлын тэмдэглэлийн үнэн зөвийг хурлын дарга хариуцна.

74.2. Хувь нийлүүлэгчдийн хурлын тэмдэглэл дараахь мэдээллийг агуулсан байна:

74.2.1. хурал болсон он, сар, өдөр, газар,цаг;

74.2.2. хурлын даргын овог, нэр;

74.2.3. хурлаар хэлэлцсэн асуудлууд;

74.2.4. хувь нийлүүлэгчдийн саналын эрхийн тоо, хурлын ирц;

74.2.5. санал авах хуудас хэрэглэсэн бол уг хуудасны загвар;

74.2.6. хурлаар шийдвэрлэсэн асуудал тус бүрээр зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо, гарсан шийдвэрийн бүрэн томьёолол.

74.3. Хувь нийлүүлэгчдийн хурлын тэмдэглэлд алдаа гарсан нь уг хурлын шийдвэрийг хүчингүй болгох үндэс болохгүй.

74.4. Хязгаалагдмал хариуцлагатай компанийн хувь нийлүүлэгчдийн хурлын санал хураалтын дүн, гарсан шийдвэрийг тухайн хурал дээр зарлан мэдэгдэнэ. Хувьцаат компанийн хувь

нийлүүлэгчдийн хурлын болон эчнээ санал хураалтаар гарсан шийдвэрийг тухайн хурал дээр, эсхүл хурал дууссаны дараа санал хураалтын дүн, гарсан шийдвэрийг хүргүүлэх замаар мэдэгдэнэ.

**75 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөл**

75.1. Хувь нийлүүлэгчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна.

75.2. Хувьцаат компани нь төлөөлөн удирдах зөвлөлтэй байх бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлгүй байж болно.

75.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог компанийн дүрмээр тогтооно.Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь 9 ба түүнээс дээш гишүүнтэй байна.

75.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь компанийн хувь нийлүүлэгч биш байж болно.

**76 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх**

76.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хууль болон компанийн дүрмээр хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

76.1.1. компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;

76.1.2. хувь нийлүүлэгчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралуулах;

76.1.3. хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийг тодорхойлох бүртгэлийн өдөр болон хувь нийлүүлэгчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;

76.1.4. компанийн зарласан хувьцааны төрөл болон хэмжээнд багтаан хувьцаа гаргах;

76.1.5. компанийн дүрэмд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах;

76.1.6. энэ хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;

76.1.7. өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;

76.1.8. компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;

76.1.9. компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл тэдгээрт олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;

76.1.10. компанийн аудиторыг сонгож түүнтэй хийх, гэрээний нөхцөлийг тогтоох;

76.1.11. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;

76.1.12. компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төлөх журмыг тодорхойлох;

76.1.13. төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журмыг батлах;

76.1.14. компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;

76.1.15. компанийг өөрчлөн байгуулах талаар хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

76.1.16. энэ хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

76.1.17. энэ хуулийн арван хоёрдугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

76.1.18. энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудлууд.

76.1.19.төрийн болон орон нутгийн өмчит буюу тэдгээр өмчийн оролцоотой /хөрөнгийн 51 буюу түүнээс дээш хувьтай/ хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэлийн аудит хийхэд энэ хуулийн 76.1.10 дахь заалт хамаарахгүй. */Энэ заалтыг 2006 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн/*

76.2. Хувьцаат компанийн хувьд энэ хуулийн 76.1.6. , 76.1.10., 76.1.17.-д заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд оролцож саналаа өгнө. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн гэж өөрөө, эсхүл эхнэр, нөхөр, эцэг, эх, хүүхэд, төрсөн ах дүү, болон нэгдмэл сонирхолтой этгээд нь сүүлийн 3 жилийн хугацаанд тухайн компанид , эсхүл түүний хараат болон охин компани эрх бүхий албан тушаал эрхэлж байгаагүй хүнийг тооцно.

**77 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох, гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох**

77.1. Энэ хууль буюу компанийн дүрмээр тогтоосон журмын дагуу хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаар төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгоно. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгосон тохиолдолд хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлаар гишүүнийг нөхөн сонгож болно. Дүрэмд өөрөөр заагаагүй тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дараа жилийн хувь нийлүүлэгчдийн хурал хийх өдрөөр дуусгавар болно.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг улируулан сонгож болно.

77.2. Хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлын шийдвэрээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно. Хэрэв төлөөлөн удирдах зөвлөлийг кумулятив аргаар сонгосон бол төлөөлөн удирдах зөвлөлийг зөвхөн бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг нь дуусгавар болгож болно.

77.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь хувь хүн байна.

77.4. Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг санал хураах кумулятив аргаар сонгоно.Энэ аргыг хэрэглэхэд энгийн хувьцаа тус бүр сонгогдох гишүүдийн тоотой тэнцэх

саналын эрхтэй байх бөгөөд хувь нийлүүлэгч нь өөрийн хувьцаанд ногдох саналаа бүгдийг нь нэг хүнд, эсхүл хэд хэдэн хүнд хуваан өгөх эрхтэй.

77.5. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсон, эсхүл нас барсан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг төлөөлөн удирдах зөвлөл нөхөн сонгууль явуулах хүртэл түр томилж болно.

**78 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга**

78.1. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.

78.2. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ.

78.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг түр эзгүйд түүний үүргийг төлөөлөн удирдах зөвлөлийн даргын томилсон, эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрлэсэн аль нэг гишүүн гүйцэтгэнэ.

78.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь үйл ажиллагааны журмаар тогтоосон эрх хэмжээний дотор компанийн нэрийн өмнөөс гэрээ байгуулах болон компанийн эрх ашгийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаагаа явуулна.

**79 дүгээр зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал**

79.1. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг сард нэг удаа хуралдуулна, шаардлагатай гэж үзвэл нэмэлт хуралдаан хийж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр нь тогтоол байна. Тогтоолд дарга гарын үсэг зурна.

79.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, түүний гишүүд, компанийн гүйцэтгэх удирдлага болон компанийн дүрэмд заасан бусад этгээдийн санаачилга шаардлагаар хуралдуулна. Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагааныхаа журмыг тогтоож батална.

Төлөөлөн удирдах зөвлөл эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.

79.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.Компанийн дүрмээр тусгайлан өндөр хувь тогтоогоогүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.Энэ хууль болон компанийн дүрэмд заасны дагуу хэрэв тухайн шийдвэрлэж байгаа асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн зарим гишүүн санал өгөх эрхгүй байвал шийдвэрийг саналын эрхтэй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо нь тогтоосон нийт гишүүдийн тооноос хоёр дахин бага болсон тохиолдолд компани нь гурван сарын дотор төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохоор хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлыг хуралдуулна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүд бүр саналын нэг эрхтэй байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд даргын саналаар асуудлыг шийдвэрлэхээр компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд зааж болно.

79.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлд дараахь зүйлийг тусгана:

79.4.1. хурал хийсэн газар болон цаг;

79.4.2. хуралд оролцсон гишүүд;

79.4.3. хурлаар хэлэлцэгдсэн асуудал;

79.4.4. санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал болон санал хураалтын дүн;

79.4.5. гаргасан шийдвэр.

Хурлын тэмдэглэлд хурал даргалагч гарын үсэг зурах бөгөөд тухайн тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцна.

79.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг буруу хөтөлсөн явдал төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

**80 дугаар зүйл. Гүйцэтгэх удирдлага**

80.1. Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

80.2. Компанийн дүрэмд гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлэхээр заагаагүй бол хувь хүн хэрэгжүүлнэ. Хувь хүн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж байгаа тохиолдолд уг этгээд компанийн гүйцэтгэх захирал байна.

80.3. Хувьцаат компанийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч этгээд нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байж болно. Харин төлөөлөн удирдах зөвлөлийн дарга байхыг хориглоно.

80.4. Хууль болон компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/-ийн зөвшөөрсөн тохиолдолд гүйцэтгэх захирал, эсхүл гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч багийн гишүүн нь өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад давхар ажиллаж болно.

80.5. Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/-тэй байгуулсан хөлсөөр ажиллах гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна. Гэрээнд төлөөлөн удирдах зөвлөлийг төлөөлж түүний дарга /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурлын дарга/ гарын үсэг зурна. Гэрээнд гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.

80.6. Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

80.7. Гүйцэтгэх удирдлагыг багийн хэлбэрээр хэрэгжүүлэх тохиолдолд компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/-тэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдож багийн гишүүдийн ажиллах дотоод журмыг төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцсөний үндсэн дээр батлан мөрдөж ажиллана. Журамд дараахь зүйлийг тусгасан байна.

80.7.1. багийн ахлагч болон гишүүдийн эрхлэх ажил үүргийн хуваарь, ажлын харилцан уялдаа холбоог зохицуулах байдал;

80.7.2. багийн ахлагчийг томилох журам;
80.7.3. багийн ахлагчийн эрх, үүрэг, хариуцлага.

80.8. Баг нь төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/-ийн өмнө компанийн үйл ажиллагааны талаар хамтын хариуцлага хүлээнэ.

Энэ хуулийн 80.5.-д заасан гэрээ, хэлцэл хийх төлөөллийг хэрэгжүүлэхэд компанийг төлөөлж багийн ахлагч гарын үсэг зурна. Багийн ахлагчийг төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөн багийн гишүүд сонгоно. Багийн ахлагч компанийн гүйцэтгэх захирлын үүргийг гүйцэтгэнэ.

80.9. Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч багийн хурал, гаргасан шийдвэрийн тэмдэглэлийг заавал хөтөлнө. Энэ тэмдэглэлийн үнэн зөвийг багийн ахлагч биечлэн хариуцна.

80.10. Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг зогсоох шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл / байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/ хэдийд ч гаргах эрхтэй.

## *АРАВДУГААР БҮЛЭГ*
## *Компанийн эрх бүхий албан тушаалтны* хүлээх хариуцлага

### 81 дүгээр зүйл. Компанийн эрх бүхий албан тушаалтны хүлээх хариуцлага

81.1. Төлөөлөн удирдах зөвлөл, хамтын гүйцэтгэх удирдлагын гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтнүүд зэрэг албан тушаал эрхэлдэг этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

81.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь компанийн дүрэм, төлөөлөн удирдах зөвлөл / байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/-ийн баталсан дотоод журамд заасан үүргийг биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана. Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/-ийн зөвшөөрснөөс бусад тохиолдолд компанийн нууц мэдээг гуравдахь этгээдэд дамжуулах, хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахыг хориглоно.

81.3. Хуульд өөрөөр заагаагүй бол компанийн эрх бүхий албан тушаалтан өөрийн хууль бус үйл ажиллагаанаас компанид учирсан хохирлыг хариуцна.

81.4. Компанийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, түүний хэмжээг тогтоох, асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээ, компанийн дотоод журмаар тогтоох бөгөөд тэдгээрийн дагуу шийдвэрлэх боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

81.5. Энэ зүйлд заасны дагуу хэд хэдэн этгээдүүд хариуцлага хүлээх бол тэд компанийн өмнө хамтын хариуцлага хүлээнэ.

81.6. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн энгийн хувьцааны 20 ба түүнээс дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувь нийлүүлэгч нь энэ хуулийн 81-д заасан эрх бүхий албан тушаалтны үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

### 82 дугаар зүйл.Хүлээх хариуцлага

82.1. Компанийн эрх бүхий албан тушаалтан санаатайгаар дараахь хууль бус үйл ажиллагаа явуулсан бол компани болон түүний хувь нийлүүлэгч, зээлдүүлэгчдэд учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцна:

**82.1.1. хувийн ашиг сонирхлын үүднээс компанийн нэрийг ашиглан аж ахуйн үйл ажиллагаа явуулсан;**

**82.1.2. компанийн хувь нийлүүлэгчид, зээлдүүлэгч болон бусад харилцагчдад хуурамч мэдээлэл өгсөн**

82.1.3. энэ хуулийн 97 дугаар зүйлд заасан шаардлага зөрчиж нэгдмэл сонирхол бүхий этгээд болохоо мэдэгдээгүй;

82.1.4. энэ хуулийн 95 дүгээр зүйлд заасан журмын дагуу компанийн бичиг баримтыг хадгалаагүй;

82.1.5. энэ хуулийн 81.2. -т заасан зарчмыг баримтлаагүй;

82.1.6. энэ хуулийн 47, 48, 49, 53 дугаар зүйлд заасны дагуу ногдол ашиг хуваарилах, хувьцаа худалдан авах эрхийн бичгийг эргүүлж худалдан авах нөхцөлийг мөрдөөгүй, төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээ, компанийн дүрмээр тогтоосон эд хөрөнгө захиран зарцуулах эрх хэмжээг хэтрүүлсэн.

82.2. Энэ зүйлд заасан хариуцлагыг энэ хууль болон бусад хуульд заасан бусад хариуцлагатай давхар хүлээлгэж болно.

**83 дугаар зүйл. Хувь нийлүүлэгчийн нэхэмжлэл гаргах эрх**

**83.1. Компанийн энгийн хувьцааны нэг ба түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанийн эрх бүхий албан тушаалтнаар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.**

83.2. Компани болон түүний энгийн хувьцааны нэг ба түүнээс дээш хувийг эзэмшигч нь компани болон өөрт учирсан хохирлыг энэ хуулийн 81.6. -д заасан этгээдээр нөхөн төлүүлэхээр энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

## АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### Их хэмжээний хэлцэл

**84 дүгээр зүйл. Их хэмжээний хэлцэл**

84.1. Их хэмжээний хэлцэлд дараахь хэлцлийг тооцно:

84.1.1. хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл; /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/

84.1.2. компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт.

84.2. Их хэмжээний хэлцлийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/ энэ хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу тогтооно.

84.3. Их хэмжээний хэлцэл мөн эсэхийг тодорхойлохдоо төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь аудиторын зөвлөмжийн дагуу эд хөрөнгийн балансын үнийг инфляцийн /мөнгөний ханшны уналт/ түвшинтэй зохицуулан шинэчилж дахин тогтоож болно.

**84.4. Нэг өмчлөгчтэй компанид энэ бүлгийн заалтууд үл хамаарна.**

**85 дугаар зүйл. Их хэмжээний хэлцэл хийх**

85.1. Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/ санал нэгтэйгээр гаргана.

Төлөөлөн удирдах зөвлөл их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг санал нэгтэй гаргаж чадахгүй тохиолдолд асуудлыг хувь нийлүүлэгчдийн хуралд оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож байгаа хувь нийлүүлэгчдийн саналын олонхоор шийдвэрлэнэ.

85.2. Их хэмжээний хэлцэл хийх асуудлаар эсрэг саналтай байсан хувь нийлүүлэгчид нь энэ хуулийн 54 дүгээр зүйлд заасан журмын дагуу өөрийн эзэмшилд байгаа хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах эрхтэй.

## АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

## Сонирхлын зөрчилтэй хэлцэл

### 86 дугаар зүйл. Сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийх хэлцэл

86.1. Компанийн эрх бүхий албан тушаалтан, компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчийг энэ хуулийн 86.2.-т заасан нөхцөлд компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх сонирхол бүхий этгээдэд тооцно.

86.2. Энэ хуулийн 86.1.-д заасан этгээд болон түүний эхнэр, нөхөр, эцэг, эх, хүүхэд, ах, эгч, дүү болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдүүд нь:

86.2.1. хэлцлийн нэг тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа;

86.2.2. хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааных нь /ногдол хувийн/ 20-иос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

86.2.3. хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн, толгойлох компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцаа ногдол хувийн 20 болон түүнээс дээш хувийг дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

86.2.4. энэ хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр илэрхийлэгдэх бусад эрхийг худалдах болон худалдан авч байгаа.

86.3. Энэ бүлгийн заалтууд дараахь тохиолдолд үл хамаарна:

86.3.1. компанийн бүх энгийн хувьцааг нэг этгээд эзэмшиж байгаа компанид;
86.3.2. хувьцаа эзэмшигч нь энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хувьцаа худалдан авах эрхээ эдлэхэд;

86.3.3. компани нь хувьцаа эзэмшигч тус бүрээс тэдний худалдахаар санал болгож байгаа хувьцааг санал болгосон нийт хувьцааны төрөл тус бүрийн тоотой хувь тэнцүүлэн худалдан авахад;

86.3.4. бусад компанийн энгийн хувьцааны 75 хувь буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа компани нь энэ хуулийн 20.4.-т заасны дагуу түүнийг нэгтгэх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулахад.

86.4. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувь нийлүүлэгчийн тоо нь 10-аас илүүгүй бол компанийн дүрэмд энэ хуулийн 86.3-т зааснаас бусад тохиолдлыг зааж болно.

### 87 дугаар зүйл. Сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийсэн хэлцлийн улмаас үүсэх хохирлыг арилгах

87.1. Сонирхол бүхий этгээдийг энэ хуулийн 88, 89 дүгээр зүйлд заасан шаардлага, журмыг зөрчиж байгуулсан хэлцлийг шүүх хүчин төгөлдөр бус гэж үзсэн бол үүний улмаас компани болон түүний хараат компанид үүссэн хохирлыг буруутай этгээд хариуцна.

87.2. Компанийн энгийн хувьцааны нэгээс дээш хувь эзэмшигч болон компанийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 87.1.-д заасан хариуцлага хүлээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

### 88 дугаар зүйл. Хэлцэл хийх сонирхол бүхий этгээдэд тавих шаардлага

88.1. Хэлцэл хийхэд сонирхлын зөрчил бүхий этгээд нь төлөөлөн удирдах зөвлөл / байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ болон аудиторт дараахь зүйлийг мэдүүлэх үүрэгтэй:

88.1.1. дангаараа буюу эхнэр /нөхөр/, эцэг, эх, хүүхэд, ах, эгч, дүү болон нэгдмэл сонирхолтой этгээдтэйгээ хамтран энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг хуулийн этгээдийн болон түүний хараат болон охин компанийн талаар;

88.1.2. өөрөө буюу эхнэр /нөхөр/, эцэг, эх, хүүхэд, ах, эгч, дүү нь эрх бүхий албан тушаалтнаар ажилладаг хуулийн этгээдийн болон түүний бүх хараат болон охин компанийн талаар;

88.1.3. компанийн хийхээр төлөвлөж байгаа хэлцлийн сонирхол бүхий этгээд болох тухайгаа.

88.2. Хэрэв шийдвэр гаргах байгууллагын бүх гишүүд нь хэлцэл хийх сонирхол бүхий этгээд биш бол хэлцэл хийх сонирхол бүхий этгээд нь уг хэлцлийн талаар шийдвэр гаргахад оролцох эрхгүй.

**89 дугаар зүйл. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийх журам**

89.1. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай хувьцаат компанийн шийдвэр, хараат болон охин компанид сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх, шаардах тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх сонирхолгүй төлөөлөн удирдах зөвлөл/байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/ -ийн хараат бус гишүүдийн олонхийн саналаар гаргана.

89.2. Сүүлийн 3 жил дор дурдсан үйл ажиллагаа эрхлээгүй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг хараат бус гишүүнд тооцно:

89.2.1. компанийн эрх бүхий албан тушаал эрхэлж байгаагүй, эсхүл уг этгээдийн эхнэр /нөхөр/, эцэг, эх, хүүхэд, ах, эгч, дүү, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь компани буюу түүний удирдах байгууллагад албан тушаал эрхэлдэггүй;

89.2.2. компанийн нэгдмэл сонирхолтой этгээд;

89.2.3.нэгдмэл сонирхолтой компанийн эрх бүхий албан тушаал эрхэлдэггүй.

89.3. Сонирхлын зөрчилтэй хэлцлээр худалдах, худалдан авах, захиран зарцуулах эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрхийн зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг энэ хуулийн 56 дугаар зүйлд заасан журмын дагуу төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.

89.4. Хувьцаат компанийн хувьд дараахь тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцэл /хоорондоо уялдаатай хэд хэдэн хэлцэл/ хийх, хараат болон охин компанид сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх буюу шаардах шийдвэрийг хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцож байгаа сонирхлын зөрчилгүй хувь нийлүүлэгчдийн саналын олонхоор гаргана:

89.4.1. энэ хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон хэлцлийн үнэ буюу эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрх, үйлчилгээний үнэ хөлс нь хэлцэл хийх тухай шийдвэр гаргах үеийн бүртгэлийн үнийн дүнгийн 2 хувиас их байх;

89.4.2. компанийн гаргах энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдан авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаасны хэмжээ нь компанийн буюу түүний хараат хувьцаат компанийн урьд гаргасан энгийн хувьцааны үнийн дүнгийн 2 хувиас их байх;

89.4.3. төлөөлөн удирдах зөвлөлийн бүх гишүүд нь /хувьцаат компанийн хувьд төлөөлөн удирдах зөвлөлийн бүх хараат бус гишүүд/ хэлцэл хийх сонирхолтой этгээд байх тохиолдолд.

89.5. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай асуудлыг хувь нийлүүлэгчдийн хуралд оруулах тухай төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөлийн хэлцэл хийх сонирхолгүй гишүүдийн олонхийн саналаар; хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн олонхийн саналаар гаргана.

89.6. Хэлцэл хийх сонирхол бүхий этгээд, эсхүл түүний эцэг эх, эхнэр, нөхөр, хүүхэд, ах, эгч, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдээс зээл авах тухай сонирхлын зөрчилтэй хэлцлийг энэ хуулийн 89.4.-т заасны дагуу батлуулах шаардлагагүй.

Энэ хуулийн 86 дугаар зүйлд заасны дагуу хэлцэл хийх сонирхол бүхий этгээдээр тооцохоос өмнө компанийн буюу түүний хараат компанийн өдөр тутмын аж ахуйн үйл ажиллагааны явцад байгуулагдсан сонирхлын зөрчилтэй хэлцлийг хувь нийлүүлэгчдийн дараагийн ээлжит хурал болох хүртэл энэ хуулийн 89.4.-т заасан журмын дагуу хувь нийлүүлэгчдийн хурлаар батлуулах шаардлагагүй.

89.7. Хувь нийлүүлэгчдийн хурал хийх өдөр компанийн буюу түүний хараат компанийн өдөр тутмын аж ахуйн үйл ажиллагааны явцад хийсэн хэлцлийг сонирхлын зөрчилтэй эсэхийг тодорхойлох боломжгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал нь хийх хэлцлийн төрөл, хэлцэл хийх этгээд болон хэлцлийн үнийн дээд хэмжээг тусгаж бусад этгээдтэй хамтран компанийн буюу түүний хараат компанийн хэрэгжүүлэх аж ахуйн үйл ажиллагааг батлах шийдвэр гаргах бөгөөд энэ нөхцөлд энэ хуулийн 89.4.-т заасан шаардлагыг хангасанд тооцно.

89.8. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай энэ бүлэгт тогтоосон журмыг тодорхой төрлийн хэлцэл хийхэд баримтлах тухай энэ хууль буюу компанийн дүрэмд заасан журмын хамт нэгэн зэрэг баримтална.

**90 дүгээр зүйл.Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах журам зөрчсөний үр дагавар**

90.1. Энэ хуулийн 86.1.-д заасан этгээд нь энэ хуулийн 88, 89 дугаар зүйлийн шаардлага, журам зөрчсөний улмаас компани буюу түүний хараат компанид учруулсан хохирлын хэмжээгээр, эсхүл хэлцлийн үр дүнд авсан зүйлээс олсон ашгийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ. Уг этгээдтэй байгуулсан хэлцлийг шүүх хүчин төгөлдөр бус гэж тооцож болно.

90.2. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн компанийн эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 82, 87 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

90.3. Энэ хуулийн 86.1.-д заасан этгээд нь энэ хуулийн 88, 89 дугаар зүйлийн шаардлага, журам зөрчсөн болон компанитай хэлцэл байгуулсан хуулийн этгээдийн бүх хувьцааг уг этгээд дангаараа эзэмшдэг нөхцөлд компани нь учирсан хохирлыг уг хуулийн этгээдээр нөхөн төлүүлэх буюу энэ хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

90.4. Компанийн энгийн хувьцааны нэгээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь, эсхүл компани нь энэ хуулийн 86.1.-д заасан этгээд, эсхүл уг этгээдийн дангаараа бүх хувьцааг эзэмшдэг хуулийн этгээдийн эсрэг шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

90.5. Энэ хуулийн 90.3.-т зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 89 дугаар зүйлд заасан журам зөрчсөн бөгөөд эдгээр зөрчлийн талаар энэ хэлцлийг байгуулсан этгээд мэдээгүй болон мэдэх боломжгүй байсан нөхцөлд уг хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцохгүй.

## АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналт

**91 дүгээр зүйл. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих аудиторын хяналт**

91.1. Дүрэмд өөрөөр заагаагүй бол компани нь санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторыг томилон ажиллуулж болно. Хувьцаат компанийн дүрэмд аудиторыг заавал ажиллуулахаар заана.

91.2. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/ аудиторыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг батална. Гэрээнд компанийн болон аудиторын эрх, үүрэг, хариуцлага, аудиторд төлөх хөлсний хэмжээг заана. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудиторын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна. Компанийн жилийн санхүүгийн тайланг баталгаажуулахын тулд ээлжит шалгалт хийнэ. Ээлжит бус шалгалтыг төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл энгийн хувьцааны 10-аас дээш хувийн эзэмшигчдийн шаардлагаар хэдийд ч хийж болно. Аудиторын ээлжит шалгалтын хөлсийг компани хариуцан төлөх бөгөөд ээлжит бус шалгалтыг түүнийг захиалж гэрээг нь байгуулж хийлгэсэн хувь нийлүүлэгч хариуцаж төлнө. Шалгалтын явцад компанийн эрх бүхий албан тушаалтан компани болон хувьцаа эзэмшигчдэд хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээд хариуцан төлнө.

91.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан аудиторын шаардлагаар компанийн санхүү-эдийн засгийн үйл ажиллагааны талаархи баримт бичгийг танилцуулах үүрэгтэй.

91.4. Аудитор нь хувь нийлүүлэгчдийн хуралд зөвхөн тайлбар өгөх үүрэгтэй оролцож болно.

91.5. Дараахь этгээдийг компанийн аудитороор сонгон ажиллуулахыг хориглоно:

91.5.1. компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилтан, эрх бүхий албан тушаалтан бол;

91.5.2. компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, эсхүл компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх эзэмшдэг бол;

91.5.3. компанитай аудитиас бусад асуудлаар аливаа хэлцэл хийсэн этгээд бол.

91.6. Аудиторын гаргасан дүгнэлтийн шинж чанараас хамааруулан олгох хөлсний хэмжээг тогтоохыг хориглоно.

91.7. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалт /баримт шалгалт/-ын дүнг үндэслэн компанийн аудитор нь дараахь мэдээллийг агуулсан дүгнэлт гаргана:

91.7.1. компанийн санхүүгийн тайлангийн үзүүлэлт үнэн зөв эсэх;
91.7.2. нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалт зохих журмын дагуу хийгдсэн эсэх, зөрчил байвал уг зөрчлийг тохиодол тус бүрээр тодорхойлох;

91.7.3. шалгалтын хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчил бүхий хэлцлүүдийн жагсаалт, уг хэлцлийг энэ хуульд заасан журмын дагуу хийсэн эсэх тухай тодорхойлолт;

**91.7.4. хувьцаат компанийн хувьд Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржээс тогтоосон бусад мэдээлллүүд;**
*/Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

**91.7.5. компанийн дүрэм болон аудитын гэрээгээр тодорхойлсон бусад мэдээллүүд.**

**92 дугаар зүйл. Хянан шалгах зөвлөл**

**92.1. Хувьцаат компани нь хянан шалгах зөвлөлтэй байх бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай компани хянан шалгах зөвлөлтэй байж болно. Хянан шалгах зөвлөлийн гишүүдийн тоо, тэдгээрийг сонгох журам, бүрэн эрхийн хугацаа, эрх, үүргийг компанийн дүрмээр тогтооно.**

92.2. Хянан шалгах зөвлөл нь компанийн дүрэм, хувь нийлүүлэгчдийн хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, компанийн удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж хувь нийлүүлэгчдийн хуралд танилцуулах, хувь нийлүүлэгчдийн санал, гомдлын дагуу компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг хянан шалгах зэрэг энэ хууль болон компанийн дүрэмд заасан бусад бүрэн эрхтэй.

**92.3. Хянан шалгах зөвлөлийн үүргийг нэг хянан шалгагч хэрэгжүүлэхээр дүрэмд тусгаж болно.**
92.4. Хянан шалгах зөвлөлийн гишүүдийг хувь нийлүүлэгчдийн хурлаас сонгоно.

92.5. Хянан шалгах зөвлөлийн гишүүд нь компанийн эрх бүхий албан тушаалтан байхыг хориглоно.

92.6. Хянан шалгах зөвлөл нь энэ хуулийн 62.2-т заасны дагуу хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахыг шаардах эрхтэй.

**93 дугаар зүйл. Компанийн нягтлан бодох бүртгэл, тайлан**

93.1. Компани нь хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргаж, хувь нийлүүлэгч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Хувьцаат компанийн хувьд Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржээс тогтоосон нэмэлт,

мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт дээрх газруудад зохих хугацаанд нь хүргүүлэн нийтэд мэдээлэх үүрэгтэй.
*/Энэ хэсэгт 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

93.2. Компанийн санхүүгийн жилийн эхлэх, дуусах хугацааг дүрмээр тогтооно.

93.3. Компани нягтлан бодох бүртгэл хөтөлж санхүүгийн тайлан гаргах бөгөөд түүний үнэн зөвийг компанийн гүйцэтгэх удирдлага хариуцна.

**94 дугаар зүйл. Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан**

94.1. Компанийн санхүүгийн тайланд дараахь зүйлийг тусгана:

94.1.1. баланс;
94.1.2. орлого, үр дүнгийн тайлан;
94.1.3. мөнгөн гүйлгээний тайлан;
94.1.4. хуримтлагдсан ашгийн тайлан;
94.1.5. тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүнгийн хамт;

94.1.6. нэмэлт тайлбар;
**94.1.7. бусад.**

Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр санхүүгийн тайланд оруулах нэмэлт зүйлийг тогтоож болно.

94.2. Татвартай холбогдон авах нэмэлт тайлбарыг Сангийн яам, хувьцаат компанийн санхүүгийн тайлангийн агуулга болон нэмэлт тайлбарын талаархи загвар, журмыг Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоож болно.
*/Энэ хэсэгт 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

94.3. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь хувь нийлүүлэгч нарт зориулан жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан илтгэл бичиж хүргүүлэх бөгөөд тайланд доорх зүйлийг тусгана:

**94.3.1. тайлангийн хугацаанд компанийн эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаархи танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, бүтэц, зохион байгуулалт, түүний өөрчлөлт;**

94.3.2. тайлангийн хугацаанд компанийн эрх бүхий албан тушаалтанд олгосон шагнал урамшил удирдлагын зардлын хэмжээ;

94.3.3. компанийн дүрмээр тогтоосон бусад мэдээлэл;
94.3.4. хувьцаат компанийн жилийн тайланд тусгах нэмэлт мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо тогтоож болно.
*/Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

94.4. Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж хувь нийлүүлэгчдийн хуралд оруулж хэлэлцүүлнэ. Хуульд заасан тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт гаргахын өмнө санхүүгийн тайланг аудитор шалгаж баталгаажуулна.

**95 дугаар зүйл. Компанийн бичиг баримтыг хадгалах**

95.1. Компани нь дараахь бичиг баримтыг хадгалах үүрэгтэй:

95.1.1. компанийн дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, компанийг байгуулах тухай үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэр, компанийн бүртгэлийн гэрчилгээ;

95.1.2. хувь нийлүүлэгчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх байгууллага болон хянан шалгах зөвлөлөөс баталсан компанийн дотоод бичиг баримт;

95.1.3. компанийн салбар болон төлөөлөгчийн газрын дүрэм;
95.1.4. нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримт;

95.1.5. хувь нийлүүлэгчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл болон хамтын удирдлагын гүйцэтгэх байгууллагын хурлын тэмдэглэл, компанийн гүйцэтгэх байгууллагын үүргийг ганцаарчлан гүйцэтгэж байгаа этгээдийн тушаал болон шийдвэрүүд;

95.1.6. хянан шалгах зөвлөлийн хурлын тэмдэглэл, хянан шалгах зөвлөл болон аудиторын дүгнэлт;

95.1.7. санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;
95.1.8. хувьцаа болон үнэт цаас гаргах журам;
95.1.9. анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн бичиг баримт;
95.1.10. компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн нэрсийн жагсаалт болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны төрөл, тоо;

95.1.11. энэ хууль болон компанийн дүрмээр тодорхойлогдсон компанийн бусад дотоод бичиг баримт.

95.2. Компани нь энэ хуулийн 95.1.-д заасан баримтыг өөрийн үйл ажиллагаа эрхлэн явуулах газар буюу хувь нийлүүлэгчдийн мэдэх, тэдний нэвтрэх боломж бүхий газар хадгална.

95.3. Компани нь өөрийн дүрэм, түүний нэмэлт, өөрчлөлтийг байнга хадгална. Энэ хуулийн 95.1.-д заасан бусад бичиг баримтыг компани нь 5 жилийн хугацаагаар хадгалах бөгөөд энэ хугацаа дуусcаны дараа эдгээр бичиг баримтыг архивт шилжүүлнэ.

95.4. Энэ хуулийн 95.1.-д заасан баримт бичгийг зохих журмын дагуу холбогдох этгээдээс хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах архивт шилжүүлэх зэрэг ажиллагааг компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /байхгүй бол гүйцэтгэх удирдлагын холбогдох албан тушаалтан / эрхлэн гүйцэтгэнэ.

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод үйл ажиллагааг биечлэн хариуцаж бичиг баримтыг хөтлөх үүрэг хүлээнэ.

**96 дугаар зүйл. Компанийн талаар мэдээлэл авах**

96.1. Хувьцаат компани нь өөрийн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн нэрс, тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны төрөл, тоо болон Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржийн дүрэм, журмаар тогтоосон бусад мэдээллийг өөрийн үнэт цаас эзэмшигчийн хүсэлтээр танилцуулах үүрэгтэй.
*/Энэ хэсэгт 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

**96.2. Компани нь анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, компанийн гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал, шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад бичиг баримттай танилцах, үнэ төлбөртэй хуулбарлан авах бололцоог хувь нийлүүлэгчдэд олгох үүрэг хүлээнэ.**

96.3. Хувьцаат компанийн энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгч, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн аль нэг хувь нийлүүлэгч нь компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэр, хаяг, эзэмшиж байгаа хувьцааны тоо зэргийг агуулсан бүртгэлийг шаардан гаргуулах эрхтэй. Компанийн гүйцэтгэх удирдлага, эсхүл хувь нийлүүлэгчдийн бүртгэл хөтлөх эрх бүхий байгууллага уг шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор шаардлага гаргасан өдрөөр тасалбар болгон бүртгэлийг гаргаж өгөх үүрэгтэй. Үүнтэй холбогдон гарах зардлыг шаардлага тавьсан этгээд хариуцна.

**97 дугаар зүйл. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, түүний талаархи мэдээлэл**

97.1. Дараахь тохиолдлыг энэ хуульд заасан компанийн нэгдмэл сонирхолтой этгээд гэж тооцно:

97.1.1. тодорхой гэрээний үндсэн дээр хамтран компанийн шийдвэрийг тодорхойлох боломж бүхий бүлэг хүмүүс ;

97.1.2. толгойлох болон хараат компаниуд;
97.1.3. нэг толгойлох компанийн хараат компаниуд;

**97.1.4. тодорхой гэрээний үндсэн дээр хамтран компанийн шийдвэрийг тодорхойлох боломж бүхий компани болон хүн /бүлэг хүмүүс/;**

97.1.5. нэг хүн / бүлэг хүн/ гаргах шийдвэрийг нь тодорхойлох боломж бүхий компаниуд;

97.1.6. компани болон уг компанийн албан тушаалтан;
97.1.7. гэр бүлийн гишүүд, эхнэр, нөхөр;
97.1.8. эцэг, эх болон хамт амьдардаг 18-аас доош насны хүүхэд.

97.2. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрсдийн эзэмшиж байгаа үнэт цаасны тухай мэдээллээ нэгдмэл сонирхолтой этгээд болсон өдрөөс хойш ажлын 30 хоногийн дотор компанид бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

**97.3. Нэгдмэл сонирхолтой этгээд нь дээр дурдсан мэдээллийг өгөөгүй буюу хугацаа хэтрүүлж өгснөөс компанид хохирол учруулбал уг хохиролыг нэгдмэл сонирхолтой этгээд хариуцна.**

## АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Бусад зүйл

**98 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

98.1. Энэ хуулийг хүчин төгөлдөр болохоос өмнө байгуулагдсан компаниуд 2000 оны 9 дүгээр сарын 01-ний дотор компанийхаа дүрмийг энэ хуульд нийцүүлэн өөрчилнө. Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс компанийн дүрмийг энэ хуульд нийцүүлэн өөрчлөх хүртэлх хугацаанд тэдгээрийн үүсгэн байгуулсан бичиг баримт нь дээр дурдсан хэм хэмжээнд харш бус байгаа хэсгээрээ хүчин төгөлдөр байна. Энэ хуулийн хэм хэмжээнд өөрийн дүрмийг нийцүүлэн өөрчлөөгүй компанийн хувь нийлүүлэгч нь компанийн дүрмийг энэ хуульд нийцүүлэн өөрчлөхийг шаардах, шийдвэр гаргуулахаар шүүхэд хандах эрхтэй.
*/Энэ хэсэгт 2000 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/.*

98.2. Энэ хуульд нийцүүлэн өөрчлөхтэй холбогдон гарсан дүрмийн нэмэлт, өөрчлөлтүүдийг бүртгэхэд компани нь хураамж төлөхгүй.

98.3. Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн компанитай холбогдох хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж нь энэ хуульд харшлаагүй бол хүчин төгөлдөр байна.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ**

***/Энэ хуулинд Монгол Улсын 2000 оны 5 дугаар сарын 12-ны, 2002 оны 7 дугаар сарын 4-ны, 2003 оны 5 дугаар сарын 23-ны, 2005 оны 11 дүгээр сарын 17-ны, 2006 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар оруулсан нэмэлт, өөрчлөлт тусгагдсан./***

***/Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 03 дугаар тогтоолоор оруулсан өөрчлөлт тусгагдсан./***